

МОДУЛЬ
6

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ



МОДУЛЬ 6

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан: Мавагийн Чанцалсүрэн

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй НҮБ-ын "Итгэлцлийн Сан"-гийн санхүүжилттэй "Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
НЭГ. ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ	13
1.1. Гамшиг, онцгой байдлын талаарх ерөнхий ойлголт	14
1.2. Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал.	15
1.3. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын онол, арга зүй	23
1.4. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын практик хэрэглээ, сайн туршлага	25
ХОЁР. ГАМШГИЙН ҮЕД ХҮҮХЭД ТОХИОЛДОХ ЭРСДЭЛ.	28
2.1. Гамшгийн үеийн эмзэг байдал, хүүхдэд тохиолдох эрсдэлийн төрлүүд	29
2.2. Гамшгийн үед хүүхдэд учирч болох эрсдэл, бэрхшээлд авах хариу арга хэмжээ.	31
2.3. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын практик хэрэглээ, сайн туршлага	36
ГУРАВ. ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА	39
3.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	40
3.2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт	43
3.3. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт.	44
ДӨРӨВ. ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН КЕЙС МЕНЕЖМЕНТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ	47
4.1. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө.	48
4.2. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	51
4.3. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент	54
ХАВСРАЛТ.	59
НОМ ЗҮЙ.	62

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх ур чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Сургалтын энэхүү багцын “Модуль 6. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал” хэсэгт бидэнтэй хамтран, гэрээлэн ажилласан Мавагийн Чанцалсүрэн болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхдийн хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатан болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.
Модуль 7 Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл	Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх.

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэлд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудыг талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
ГБХЗХГ	Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар
ГССҮТ	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
ГХтХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
ГХУСАЗЗ	Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБАНДЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн Засгийн Нийгмийн Комисс
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НХАХ	Нийгмийн хамгааллын арга хэмжээ
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УИХ	Улсын Их Хурал
УОК	Улсын Онцгой Комисс
ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХНХЯ	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам
ХХКМ	Хүүхэд хамгааллын кейс менежмент
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Амьдрах ухаан	Өдөр тутмын ахуй амьдралд тулгардаг сорилт, саад бэрхшээл, хэрэгцээ шаардлагаа үр дүнтэй шийдвэрлэх, түүнд дасан зохицох хувь хүмүүсийн зан байдлын эерэг хандлага, амьдралын ухаан, ур чадварыг хэлнэ (MNS 6948:2021).
Амьжиргаа	Хүнд амьдрахад шаардлагатай чадвар, эд хөрөнгө, боломж болон үйл ажиллагааны цогцыг хэлнэ (MNS 6948:2021).
Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Эцэг эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг хэлнэ (MNS 6948:2021).
Аюул	Хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.5).
Аюулгүй байдал	Аюул, осол, эрсдэл, гэмтэл бэртлээс хамгаалагдаж байх нөхцөл байдал бие махбод, хүрээлэн буй орчин, нийгэм, оюун санаа, улс төр, сэтгэл зүйн хохирлоос ангид байх хүмүүсийн бие махбодын, хувь хүний сайн сайхан, бүрэн бүтэн байдлыг хэлнэ (MNS 6948:2021).
Аюулгүй орон зай	Хүүхдэд аюулгүй орчныг бүрдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор хүмүүнлэгийн байгууллагын хэрэглэдэг арга хэмжээг хэлнэ (MNS 6948:2021).
Аюулт үзэгдэл	Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.2).
Боломжийг бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлж, саад тотгорыг арилгасан, эсвэл нөлөөг нь бууруулсан арга хэмжээг хэлнэ.
Бэлгийн дарамт	Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг үйлдлийг ойлгоно (ЖЭТБТХ).
Бэлгийн мөлжлөг	Бусдын эмзэг дорой болон эрх мэдлийн давуу байдал, итгэлцлийг ашиглан бэлгийн харилцаанд татан оролцуулж, бэлгийн мөлжлөгөөс мөнгө, нийгмийн болон улс төрийн ашиг, хонжоо олж буй бодит үйлдэл юм уу оролдлогыг хэлнэ (MNS 6948:2021).

Бэлэн байдал	Гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.24).
Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.7).
Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үед хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг, дарамтад хүүхдийг өртөхөөс урьдчилан сэргийлж хамгаалах, арга хэмжээ авахыг хэлнэ (MNS 6948:2021).
Гамшгийн хор уршгийг арилгах	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.14-т заасан үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.15).
Гамшгийн хор уршиг	Гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.14).
Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	Гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.8).
Гамшиг	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.1).
Гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэд	Эцэг эхийн аль алианаас нь эсвэл хууль ёсны асран хамгаалагч болон тэдний өмнөөс тухайн хүүхдийг хамгаалах үүрэгтэй хүмүүсээс тусгаарлагдсан хүүхдийг хэлнэ (MNS 6948:2021).
Даван туулах, дасан зохицох чадвар	Хувь хүн, хамт олон, нийгэм, улс орон байгалийн гамшиг, хямралыг урьдчилан харж, тэдгээрийн сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээх, тулгарсан бэрхшээлийн хор хөнөөлийг даван туулах, эрүүл мэнд, хөгжил, сайн сайхан байдлаас хангуулах, өөрсдийн эрхийг хэрэгжүүлэх чадварыг хэлнэ (MNS 6948:2021).
Дотоодын шилжин суурьшсан иргэд	Байгалийн болон хүнээс үүдэлтэй гамшгийн үр дагавраас зайлсхийх зорилгоор гэр орон оршин суугаа газраа албадлагаар орхин явах, эсвэл орхин явах үүрэгтэй олон улсын хил даваагүй хүн, бүлэг хүмүүсийг хэлнэ (MNS 6948:2021).
Дүрвэгсэд	Дүрвэгсдийн тухай конвенцод (1951) зааснаар дүрвэгч нь “арьс өнгө, үндэс угсаа, иргэншил, нийгмийн тодорхой бүлэг, улс төрийн үзэл бодол зэргээс болж мөрдөгдөн, айдас нүүрлэсэн, өөрийн улсын хамгаалалтад орох хүсэлгүй буюу эх орондоо буцах боломжгүй, иргэншил бүхий эх орноосоо өөр улсад байгаа хүн” гэж тодорхойлсон байдаг.

Кейс менежмент	Тохиромжтой арга барилаар, системтэйгээр, цаг тухайд нь шууд тусламж үзүүлэх, эсвэл шаардлагатай мэдээлэл үйлчилгээтэй нь холбох замаар хүүхэд болон тэдний гэр бүлийн хэрэгцээг шийдвэрлэх арга барил, хандлагыг хэлнэ (MNS 6948:2021).
Кейс менежер	Кейс менежментийн үед тухайн кейсийг илрүүлэхээс хэлээд хаах хүртэл хүүхдэд анхаарал тавих үүрэгтэй ажилтныг хэлнэ (MNS 6948:2021).
Мэргэжлийн анги	Сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.17).
Нэрвэгдэгсэд	Гамшиг, аюулын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэдийг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.12).
Орчныг бэхжүүлэх	Хүний эрхийн хэрэгжилтийг бүрэн хангасан нийгмийн орчныг бий бэхжүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг ойлгоно. Энэхүү үйл ажиллагаанд төрийн бодлого, нийгмийн хандлага, итгэл үнэмшил, зан үйл, хууль тогтоомжид бүтцийн өөрчлөлт хийх зорилго агуулдаг.
Осол	Уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.3).
Саад тотгор	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоонд саад учруулж, бэрхшээлийг бий болгодог орчны хүчин зүйлсийг хэлнэ. Эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломжийг хязгаарладаг. Саад тотгор нь хандлага, амьдарч буй орчин болон институцийн байж болно. ¹
Садан төрлийн асрамж халамж	Эцэг эх нь биш боловч тухайн хүүхэдтэй гэр бүл, садан төрлийн чухал холбоотой хүн хүүхдийг бүтэн цагаар асрах, хамгаалах, хүмүүжүүлэхийг хэлнэ (MNS 6948:2021).
Сэтгэл зүйн цочрол гэмтэл	Хувь хүний амь нас эсвэл сэтгэл санаанд ноцтой эсвэл амь насанд аюултай үйл явдал нэг удаа эсвэл урт хугацаанд давтан үргэлжилж улмаар сэтгэц, бие махбод, нийгмийн, сэтгэл санаа, оюун санааны сайн сайхан байдалд урт хугацаанд сөргөөр нөлөөлөх байдлыг хэлнэ (SAMSHA, 2014, p.7).
Тэгш хамруулах хандлага	Нийгмийн суурь үйлчилгээний гадуур үлдэх эрсдэлтэй бүх хүмүүст үйлчилгээг тэгш хүртээх, эдгээр үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд тэдний дуу хоолойг хүргэх зорилготой эрхэд суурилсан хандлагыг ойлгоно (MNS 6948:2021).
Үйлчлүүлэгч	Хамгаалалтын кейс менежментийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хувь хүн, хүүхдийг хэлнэ.
Хамгаалах хүчин зүйлс	Хувь хүн, олон нийт, нийгмийн давуу тал, онцлог, нөөц, боломжид тулгуурлан тэдэнд тулгарах аливаа эрсдэлээс сэргийлэх, учирсан бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэх хүчин зүйлсийг хэлнэ. ²
Хараа хяналтгүй хүүхэд	Хууль ёсны болон өв уламжлалын дагуу хариуцлага хүлээх үүрэгтэй эцэг эх, бусад насанд хүрсэн хамаатан садан нь харж хандаагүйгээс тэднээс тусгаарлагдсан хүүхдийг хэлнэ.

1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц. 9-р зүйл. 2008 он.

2 А.Батхишиг. (2019) Нийгмийн ажил хамгаалах хүчин зүйлс. УБ. хууд.37

Хойшлуулшгүй сэргээн босгох	Гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг ойлгоно (ГХТХ-ийн 4.1.16).
Хорио цээрийн дэглэм	Цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, таслан зогсоох зорилгоор халдварласан, халдвар тээгч, халдварласан байж болзошгүй сэжиг бүхий болон тэдгээрийн харьцагч, хавьтагч хүн, мал, амьтан, эд материалыг тусгай нөхцөлд тогтоосон хугацаагаар бусдаас тусгаарлах, эмчлэх, сувилах, хяналт-ажиглалтад байлгах, ариутгахыг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.22).
Хохирогч-төвтэй арга зүй	Хохирогчийн эрх ашиг, үзэж туулсан амьдрал, шийдвэрийг бүхий л үйл ажиллагааныхаа гол цөмд тавихыг хэлнэ. Энэхүү арга зүй нь үйлчлүүлэгчийн орчин, давуу тал болон сэтгэл зүйн гэмтэлд суурилдаг (ACFID 2021).
Хүмүүнлэгийн тусламж	Иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.21).
Хүний эрхэд суурилсан арга зүй	Олон улсын хүний эрхийн конвенцод үндэслэсэн үзэл баримтлал нь олон улсын болон үндэсний холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ард иргэд өөрийн эрхээ үүрэг хүлээгчдээс шаардах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь угсаа гарал, болон бусад байдлын ялгаанаас үл хамааран ямар нэг гадуурхалгүйгээр амьдрах эрхтэй гэсэн зарчимд тулгуурладаг. Гэвч энэхүү эрхийг хангахын тулд нэлээдгүй их бэрхшээл саадтай учирдаг.
Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үеийн хүүхдийн хамгаалал	Хүмүүнлэгийн ажил явуулахдаа дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, авах хариу арга хэмжээг хэлнэ (MNS 6948:2021).
Хүүхдийн аюулгүй байдлыг хангах	Байгууллага тэдний ажилтан, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хөтөлбөр нь хүүхдэд гэм хор учруулахгүй байхыг хариуцахыг хэлнэ (MNS 6948:2021).
Хүртээмжтэй байх	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох үүднээс олон нийт, хөдөө орон нутаг эсхүл хот суурин газрын хаана ч хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа үүнд мэдээллийн технологи, систем болон нийтийн үйлчилгээ эсхүл нийтэд зориулсан бусад төрлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, үйлчилгээг бусдын адил хүртэх боломжийг хангасан байхыг хэлнэ. ³
Хүүхдийн оролцоо	Хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах, аливаа өөрчлөлт хийхдээ, хүүхэд бүрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх, тэдний үзэл бодлыг гаргаж буй шийдвэрт тусгах ойлголтыг хэлнэ. ⁴
Хүүхдийн хөдөлмөр	Хүүхдийн сэтгэл санаа, бие махбодод аюултай, олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн хор хөнөөл, эрсдэл учруулах ажлыг хэлнэ (MNS 6948:2021).

3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, 9-р зүйл, 2008 он.

4 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага. MNS 6948:2021)

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ. ⁵
Хүүхдэд ээлтэй арга зүй	Хүүхдийг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний нас, хөгжлийн бэрхшээл, өсөж хөгжиж буй чадвар, ялгаатай байдал, чадавхыг анхаарч ажиллах ажлын арга барилыг хэлнэ. ⁶
Хүүхдэд ээлтэй орон зай	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн зүгээс (хүмүүнлэгийн салбар) хүүхдийн эрхийг хангаж, тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд бүтээсэн аюулгүй орчныг хэлнэ. ⁷
Хүүхэд	18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ.
Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги	Гамшиг онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амь насыг аврах, эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах, осол гэмтэл, хүчирхийлэл, үл хайхралт, мөлжлөгөөс хамгаалах, зохистой хариу арга хэмжээ авах, хүүхдэд ээлтэй орон зай болгох гэх мэт хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах үүрэгтэй нэгжийг хэлнэ. ⁸
Хязгаарлалтын дэглэм	Засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлах үйл ажиллагааг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.23).
Цар тахал	Тахал үүсгэж буюу өвчний шинж, түүний эсрэг авах арга хэмжээ өөрчлөгдөөгүй боловч хамрах хүрээ тэлсэн байдлыг хэлнэ.
Эмзэг байдал	Болзошгүй аюулд аливаа зүйлс өртөх магадлалыг ойлгоно (Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 4.1.6).
Эрсдэлт хүчин зүйлс	Эрсдэлийн эх үүсвэр бөгөөд тухайн хүний байгаа орчин нөхцөлөөс илүү өргөн хүрээний аюул, саад тотгорыг илэрхийлдэг. Эдгээр нь нийгэм экологийн (бие махбод, нийгэм, эдийн засаг болон орчны үйл явц) нэг хэсэг болж хувь хүний тодорхой шинж чанартай харилцан үйлчилж, тэдний эрхийг зөрчих магадлалыг нэмэгдүүлдэг.
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэлнэ (Эрүүл мэндийн тухай хууль 3.1.3).
Эрэн хайх, аврах ажиллагаа	Голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг хэлнэ (ГХТХ-ийн 4.1.10).

5 Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016 он

6 Мөн тэнд

7 Мөн тэнд

8 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага. MNS 6948:2021

НЭГ

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ


- 1.1 Гамшиг, онцгой байдлын талаарх ерөнхий ойлголт
- 1.2 Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал
- 1.3 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын онол, арга зүй
- 1.4 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын практик хэрэглээ, сайн туршлага

1.1

ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Дэлхий даяар хүн амын өсөлт, шинжлэх ухааны ололт нээлт, нийгэм-эдийн засгийн болон технологийн үсрэнгүй хөгжил, байгаль цаг уурын өөрчлөлт, даяаршил шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж байна. Хүрээлэн буй орчны эерэг, сөрөг өөрчлөлт нь хувь хүн, гэр бүл, хамт олон, олон нийт, улс орны эдийн засаг, хүн ам зүйд тухайн улс орны хөгжлийн түвшин, засаглалын чадавх, газар зүйн байршил зэрэг олон талт хүчин зүйлийн улмаас харилцан адилгүй нөлөөлж байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай манай улсад дулаарал дэлхийн дунджаас даруй 3 дахин их эрчимтэй явагдаж байгааг эрдэмтэд судлан тогтоожээ.⁹ Энэхүү өөрчлөлтийн улмаас цаг уурын гамшигт үзэгдлийн давтамж олширч, илүү хүчтэй болсоор байна. Нөгөө талаас удаан хугацаанд үргэлжилж буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдал нь бусад улс орнуудын адил манай орны улс төр, нийгэм эдийн засаг, иргэдийн сэтгэл зүйд бусад орны нэгэн адил хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Иймээс төрөөс гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах үндэсний чадавхыг бэхжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт тавих болсон.

Гамшиг нь нийгмийн үйл ажиллагааны ноцтой сүйрэл бөгөөд хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй байгаль орчинд их хэмжээний хохирол учруулдаг ба энэ үед хүмүүс өөрсдийн нөөц бололцооноос давж гарах боломжгүй, онцгой нөхцөл үүсдэг. Тодруулбал, гамшиг гэдэг олон нийт тэвчиж чадашгүй онцгой байдлыг хэлнэ.¹⁰



Гамшгийн аюул. Аливаа гамшгийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад улс орны гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа холбоо, бүх талын хамтын ажиллагааны зохицуулалт нэн чухал үүрэгтэй. Гамшгийг хүний хүчин зүйлс болон байгалийн хүчин зүйлс гэсэн үндсэн хоёр төрөлд ангилдаг бөгөөд гамшгийн онцлог шинж, нөлөөлөх хүчин зүйлс зэргээс шалтгаалан олон арга аргачлалаар ангилдаг (Р.Ганбат, 2017).

⁹ ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Л.Болдбаатар. 2022 он. Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал илтгэл. Төрийн ордон. 2022 оны 05 сарын 27. "Хүүхдэд ээлтэй Монгол" үндэсний чуулган, Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөлдөөн.

¹⁰ Хүүхдийг Ивээх Сан, 2017, Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал

Хүснэгт 1. Гамшгийн аюулын ангилал, онцлог шинж, нөлөөлөх хүчин зүйлс

	Онцлог шинж	Нөхцөл байдал	Төрөл
1	Гарал үүсэл	Байгаль, цаг агаарын	Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, хөрсний гулгалт, нуралт, далайн хар шуурга, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, цөлжилт, зуд, цочир хүйтрэлт, мөндөр, аянга цахилгаан, ой хээрийн гал түймэр
		Биологийн	Хүний гоц халдварт өвчин (Олон улсын хөл хориотой өвчин), томуугийн шинэ дэд хэвшлийн халдвар, малын болон ургамлын гоц халдварт өвчин, хөнөөлт мэрэгчид, хортон шавжийн тархалт гэх мэт
		Техник, технологийн	Үйлдвэр, уул уурхай, агаарын, усан, авто, төмөр замын тээврийн осол, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, Объектын гал түймэр, тэсрэлт дэлбэрэлт
		Экологийн	Агаар, хөрс, усны бохирдол, азоны цоорхой, хүчилтөрөгчийн дутагдал, ургамал, амьтны төрөл зүйл өөрчлөгдөх
		Нийгмийн	Дайн байлдаан, өлсгөлөн, алан хядах ажиллагаа, үй олныг хамарсан эмх замбараагүй байдал
		Холимог буюу хавсарсан	Хоёроос дээш гамшгийн аюул зэрэг тохиолдох
2	Хамрах хүрээ	Дэлхий дахин	Хэд хэдэн улс, тив дамнасан
		Бүс нутгийн)	Хөрш орнуудын
		Үндэсний	Хэд хэдэн аймаг, нийслэлийн түвшинд
		Орон нутгийн	Сум, хороо, аймгийн түвшинд
		Хэсэгчилсэн	Баг, хорооны хэмжээнд
		Объектын	Аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд
3	Хүний хүчин зүйл	Санаатай	Зориуд
		Санамсаргүй	Болгоомжгүй
4	Урьдчилан сэргийлэх боломжтой эсэх	Боломжтой	
		Боломжгүй	
5	Хурд	Тэсрэлтийн	Асар богино буюу хэдэн секундээс минут хүртэл
		Маш хурдтай	Гэнэтийн, хэдэн минутаас цаг хүртэл
		Хурдтай	Хэдэн цагаас хэдэн өдөр хүртэл
		Аажим буюу алгуурхан	Хэдэн өдрөөс хэдэн сар, жил

1.2

ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Монгол улс нь хүний эрхийн олон улсын хуулийн хүрээнд төрөөс авч хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаандаа нэн түрүүнд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 7.3 зорилт (2021-2030)-д уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий

байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхээр тусгасан.

НҮБ-ын гишүүн улс орнуудын эрүүл мэнд, гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг бууруулах, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр үүрэг амлалт өгч, хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийг баталсан. Тухайлбал:

- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030,
- Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030
- Томуугийн цар тахлын эсрэг бэлэн байдал, үйл ажиллагааны хүрээ 2010
- Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын онцгой байдлын үед дэлхийн хэмжээнд хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн үйлчилгээ
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр
- Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлын хөтөлбөр
- Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт 2030 зэрэг бодлогын баримт бичгүүд нь гамшгийн үеийн бэлэн байдлын хангахад чиглэдэг.

Олон улсын хүний эрхийн стандарт, ялангуяа олон улсын хүүхдийн эрхийн стандартад нийцүүлэн үндэсний гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх замаар гамшгийн үед хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний уялдааг хангах боломжтой. Гамшиг, аюулын хүүхдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны тулгамдсан асуудал нь гамшиг хямралын үед тэсвэрлэх чадвартай хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, бэхжүүлэх асуудал юм.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.3.21-д "Гамшиг судлалын судалгаа шинжилгээг хөгжүүлж, гамшгаас учирсан хохирол, сэргээн босгох хэрэгцээг тооцох арга, технологи боловсруулж, гамшгийн мэдээллийн сан, үндэсний гамшгийн менежментийг хөгжүүлэх"-ээр заасан. Энэ хүрээнд гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллыг сурталчлах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд тэргүүлэх ач холбогдол өгөх нь эхний чухал алхам юм.

Гамшиг, хүмүүнлэгийн үйл ажиллагааны бүхий л салбарт хүүхэд хамгааллыг нэгтгэж, яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох үйл ажиллагааны төвд хүүхэд байх ёстой. Тиймээс Салбар дундын бүлэг нь СХЗГ-аас 2021 онд баталсан Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал MNS 6948:2021 үндэсний стандартыг гамшгийн үед хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй бүх шатанд бүх хүнд танилцуулж, хэрэгжилтийг хангах замаар хүүхдийн хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх боломжтой.

Хүүхдийг Ивээх Сан хүүхэд хамгааллыг хүүхдийн эсрэг дарамт хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажиллагаа, бүтэц гэж тодорхойлдог. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод зааснаар хүүхэд дарамт хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах эрхтэй. Аливаа гамшиг, онцгой байдлын үед дараах байдлаар гадуурхагдсан 4 бүлэг хүмүүс эрсдэлд өртөх хамгийн их магадлалтай байдаг¹¹. Үүнд:

1. хүйс (эмэгтэйчүүд, жирэмсэн эхчүүд)
2. нас (хүүхэд, хөгшид)
3. үндэстэн ястан эсвэл гадаад хүмүүс (дүрвэн ирэгсэд, жуулчид г.м)
4. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Энэ дотроос хамгийн их хохирол амсдаг бүлэг нь хүүхдүүд юм. Хэдийгээр гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн хэрэгцээ шаардлагад ихээхэн анхаарал тавьж байгаа боловч болзошгүй

11 Мөн тэнд

гамшгийн үед тэдний эмзэг байдлыг бууруулах арга хэмжээний талаар маш бага анхаарч иржээ. Гамшгийн менежментийн гарын авлага, удирдамжид хүүхдэд туслах үйл ажиллагааг ихэвчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй нь холбож, тэднээр дамжуулах нь хамгийн сайн үр дүнтэй байдаг гэж үздэг. Ер нь хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн амын нэг ангилал болгон ойлгосоор ирсэн нь хүүхдийн эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байгаа юм.

- Хүүхэд нас, биеийн хөгжлөөс шалтгаалж эцэг эхээсээ их, зарим үед бүрэн хамааралтай байж болно.
- Тэдний өдрийн хуваарь өрх доторх насанд хүрэгчид ялангуяа эхийнхээ ажилтай нягт холбогддог.
- Хүүхдүүд хэдий гамшгийн тухай мэдлэгтэй байсан ч туршлага дутах явдал түгээмэл байдаг.

Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийг хамгаалах гэдэг нь аливаа гамшгийн дараа хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийг дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал нь гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарч, хүүхдийг аливаа хүчирхийллээс хамгаалж, тэдний амь нас, сайн сайхан байдлыг хангахад чухал ач холбогдол өгдөг.

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаа нь i) гамшгийн үед болон дараа хүүхдийн амь насыг аврах, нэр төрийг хамгаалах, хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд үүссэн сөрөг нөлөөг бууруулах, ii) гамшгийн болзошгүй аюул, хямралын үеийн бэлэн байдлыг бэхжүүлдэг (Action, 2019).

Шигтгээ 1-т үзүүлсэн “Уур амьсгалын өөрчлөлтөд суурилсан хүүхэд хамгаалал” аргачлал нь үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ хүртэгчдийн хооронд итгэлцлийг бий болгоход чухал хөшүүрэг болдог бөгөөд гамшигт өртөмтгий, нийгмийн эмзэг бүлгийг тодорхойлж, чадавхжуулах, тэдний эмзэг байдлыг бууруулах, арилгахад чиглэсэн хамгаалах тогтолцоог бүрдүүлэх замаар гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг нарийвчлан авч үздэг байна. Уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг хүчин зүйлс, тухайлбал ургац алдах, хоол хүнсний болон усны хомсдол үүсэх, ган, үер, далайн хар шуурга зэрэг цаг агаарын аюулт үзэгдлийг бий болгодог. Эдгээр нь өрхийн ядуурал, эмзэг нөхцөл байдалд сөрөг үр дагавар учруулж, улмаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлдөг (Eberechi Nnah-Ogbonda, 2021).

ОБЕГ-ын “Хүүхэд хамгааллын тухай илтгэл”-д (Болдбаатар, 2022) өгүүлснээр жилд тохиолдох байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн тоо өсөх тусам гамшигт өртөх хүүхдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгааг анхааруулсан. Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд 675 хүүхэд байгалийн аюулт үзэгдэл, гамшиг, ахуйн осолд өртсөнөөс, тэдний 48 хувь нь гол усны аюулд, 39 хувь нь ой хээрийн түймэрт өртөж амь насаа алдсан байна. Эдгээрийн үндсэн шалтгаанд эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт дутмаг, хүүхдийн цэцэрлэг сургуулийн хүртээмжгүй байдал, хүүхэд чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай боломж хомсдол зэргээс үүдэлтэйг судлан



Шигтгээ 1. Уур амьсгалын өөрчлөлтөд суурилсан хүүхэд хамгаалал

Уур амьсгалын өөрчлөлтөд суурилсан хүүхэд хамгаалал гэдэг нь өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан, уур амьсгалын нөлөөллийн улмаас цаашид бий болох эрсдэл, учирч болзошгүй саад бэрхшээлийг урьдчилан тодорхойлж, бэлэн байдлыг хангахдаа хүүхэд хамгааллын асуудлыг бүх шатанд авч үзэх явдал юм.

Эх сурвалж: Barnfonden. 2021. Exploring the link between climate change and violence against children, Literature review. p.3, 29.

тогтоожээ.¹² Энэхүү статистик баримт нь гамшгийн өмнө ч, гамшгийн үед ч нийгмийн бүхий л түвшинд хүүхэд хүчирхийлэлд өртсөөр буй гунигтай дүр зургийг харуулж байна.

Зураг 1. Гамшгийн эрсдэлт хүчин зүйлс



Зураг 1-т үзүүлсэн эрсдэлт хүчин зүйлсээс улбаалж гамшгийн үед хүүхдийн хамгаалуулах эрх зөрчигдөн, аюулгүй байдал алдагдсанаар амь нас, эрүүл мэндэд аюул учрах, сэтгэл зүйн цочролд орох, үл хайхрагдах, санамсаргүй болон санаатай байдлаар гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх, бие махбод болон бэлгийн хүчирхийлэлд өртөх, бэлгийн дарамт болон эдийн засгийн мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгдэж, улмаар амь насаа алдах нөхцөл байдал үүсэж болно.

Гамшиг онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэхэд чиглэнэ. Үр дүнтэй хүүхэд хамгаалал нь гамшигтай тэмцэх улс орны одоогийн чадавхыг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлдэг. Гамшгийн онцгой нөхцөл байдлын үед амь насыг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг цаг хугацаанд нь авснаар хүүхэд, гэр бүл, олон нийтийн эрүүл мэнд, сэтгэл санаа, нэр төр, сайн сайхан байдлыг цаг алдалгүй хамгаалж чадна (Action, 2019).

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын зарчим¹³

Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед бүх түвшинд хүүхдийг хамгаалах үндсэн 10 зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөнө (СХЗГ, 2021; Action, 2019). Эдгээр зарчим нь нэн түрүүнд Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК), хүмүүнлэгийн эрх зүй, хүмүүнлэгийн зарчмууд болон гамшиг онц байдлын үеийн туршлага, сургамжаас үүдэлтэй.

12 ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Л.Болдбаатар. 2022 он. Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал илтгэл. Төрийн ордон. 2022 оны 05 сарын 27. "Хүүхдэд ээлтэй Монгол" үндэсний чуулган, Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөлдөөн.

13 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага, MNS6948:2021

Зураг 2. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын зарчмууд



Зураг 2-н голд харуулсан 1-4 дүгээр зарчим нь ХЭК-ийн дөрвөн үндсэн зарчим бөгөөд (НҮБ, 1989) гамшгийн үеийн бүх үйл ажиллагаанд хамаарна. Үндсэн дөрвөн зарчим дээр тулгуурлан дараах 10 зарчмыг 2021 онд ХНХЯ-наас баталсан “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021” стандартад зааж өгсөн байдаг. Үүнд:

Нэгдүгээр зарчим. Эсэн мэнд амьдрахуй ба хөгжил

Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй ба бие бялдар, сэтгэл зүй, сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшихүйн хөгжилд гамшиг, онцгой байдлын үзүүлэх хор уршгийг анхаарч, хариу арга хэмжээ авахдаа эсэн мэнд амьдрах, сурч, боловсрох, хөгжих эрхээ өөрт байгаа давуу тал, даван туулах чадвараа ашиглан эдлэхэд нь хүүхдэд нь дэмжлэг үзүүлнэ.

Хоёрдугаар зарчим. Үл ялгаварлал ба тэгш хамруулалт

Олон улсын хууль тогтоомжийн дагуу тухайн улс орны нутаг дэвсгэрт амьдарч буй бүх хүүхдэд ялгаварлан гадуурхлаас ангид байж, Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан эрхээ эдлэх нь тэгш боломж олгоно. Гамшгийн үеийн хүүхэд бүрийн заяагдмал нэр төр, ялгаатай байдлыг хүндэтгэж, хүүхдийг байгаагаар нь хүлээн зөвшөөрнө.

Хүүхэд бүр жендэр, бэлгийн чиг баримжаа, нас, яс үндэс, цагаачлалын статус болон бусад ялгаатай байдлаас үл хамааран ялгаварлан гадуурхалтаас ангид байна. Шууд болон шууд бус ялгаварлан гадуурхлын шалтгаан, хэлбэрийг илрүүлж, зохих арга хэмжээг авна. Хүмүүнлэгийн ажилтан хүүхэд болон тэдний гэр бүлийн асуудалд хувийн үнэт зүйл, өрөөсгөл үзэл бодлын үүднээс хандахгүй.

Гуравдугаар зарчим. Хүүхдийн оролцоо

Хүмүүнлэгийн ажилтан гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үед хүүхдэд

өөрийн эрхэд нь нөлөөлөхүйц бүхий л шийдвэрт утга учиртай оролцох, сонирхлоо илэрхийлэх бололцоо, цаг хугацаа, орон зайг гаргаж өгнө. Жендэр, нас, зан суртахуун, сэтгэц, хөгжлийн бэрхшээл, харилцааны хэлбэр, нөхцөл байдал, аюулгүй байдалд тохируулан хүүхдийн оролцоог дараах байдлаар хангана. Үүнд:

- Хүүхдийн нас, хүйс, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон оролцооны хэлбэрийг сонгох;
- Шийдвэр гаргах эрх мэдэл мэдлийг хүүхэдтэй хуваалцах;
- Хүүхдийн санаа бодол, хүсэл сонирхлыг харгалзан үзэх;
- Хүүхэд шийдвэр гаргахад оролцооноор түүний гэр бүл, орон нутаг дахь байр суурь өөрчлөгдөх талтай гэдгийг тооцоолох

Оролцоо нь ямагт сайн дурын үндсэн дээр, хүүхэд болон түүний эцэг эх/асран хамгаалагчийн зөвшөөрөлтэй.

Дөрөвдүгээр зарчим 4. Хүүхдийн дээд ашиг, сонирхол

Нийгэм болон хувь хүнтэй холбоотой, хүүхэд хамааралтай бүхий л үйл ажиллагаа, шийдвэрт хүүхдийн дээд эрх ашиг, сонирхлыг хүндэтгэнэ. “Хүүхдийн дээд ашиг, сонирхол” гэдэг нь ерөнхий утгаараа хүүхдийн сайн сайхан байдал мөн. Сайн сайхан байдал нь хувь хүний жендэр, нас, хөгжил, амьдралын туршлага гэх мэт ялгаатай нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсээс (эцэг эхтэй эсэх, хүүхэд болон гэр бүл/асран хамгаалагч хоёрын хоорондын харилцаа, бусад эрсдэл, чадавх) шалтгаална.

“Хүүхдийн дээд эрх ашиг, сонирхол” гэх ойлголт нь гурван талтай. Үүнд:

- Хүүхдийн үндсэн эрх: хүүхдийн дээд эрх ашиг, сонирхлыг хангаж буйг үнэлж, тэргүүн ээлжид авч үзнэ;
- Эрх зүйн зарчим: эрх зүйн заалт нь олон тайлбартай бол хүүхдийн дээд эрх ашиг, сонирхолтой илүүтэйгээр нийцэх тайлбарыг сонгоно;
- Гүйцэтгэлийн дүрэм: хүүхэд, бүлэг хүүхдэд үйлчлэх шийдвэр гаргахдаа (а) хүүхдэд үзүүлэх үр нөлөөг тооцох, (б) хүүхдийн дээд эрх ашиг сонирхлыг тооцож тэргүүн ээлжид авч үзсэн гэдгийг нотолсон байна.

“Хүүхдийн дээд эрх ашиг, сонирхол”-ын зарчмыг хүмүүнлэгийн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хянан сайжруулахад ашиглаж тодорхой давтамжтай хянаж үнэлнэ. Хүүхдийн дээд ашиг, сонирхлын зарчим нь хүүхэд бүрд, тэр дундаа гамшигт өртсөн улсын иргэд, орогнол хүсэгчид, дотооддоо шилжин суурьшигчид, дүрвэгсэд, хил давж шилжин суурьшигчид, иргэний харьяалалгүй хүүхдэд ялгаагүй үйлчилнэ. Энэ зарчим нь бүх нөхцөл байдал, тэр дундаа хүмүүнлэгийн хямралын үед хүүхэд өөрийн эцэг эх/асран хамгаалагчтай эсвэл эцэг эхээсээ төөрсөн, салсан зэргээс хамааралгүйгээр бүх хүүхдэд үйлчилнэ. Хүүхдийн дээд эрх ашиг, сонирхлыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хүүхдийг өөрийг нь оролцуулна. Хүүхдийг оролцоог дараах байдлаар хангана. Үүнд:

- Хүүхдэд мэдээлэл өгөх;
- Хүүхдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих;
- Аливаа шийдвэрт хүүхэд, түүний эцэг эхийн санаа бодлыг тусгах

Тавдугаар зарчим. Хүүхдийн аюулгүй байдал, нэр төр, эрхийг хамгаалж, нэмж хохирол учруулахгүй байх

Хүмүүнлэгийн ажилтан эрсдэлийг бууруулах, эмзэг байдлыг багасгах, тэр дундаа хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүнд хүмүүст нэмэлт эрсдэл, хор хохирол, хүчирхийлэл учруулахгүй байхад

анхаарна. Хүмүүнлэгийн арга хэмжээг төлөвлөхдөө байршил, цаг хугацаа, тээвэр ариун цэврийн байгууламж зэргийг бүх хүүхдэд хүртээмжтэй, тэгш хамруулсан, нөхцөл байдалд нийцсэн байхаар тооцно. Хүүхдийн тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн мэдээллийн бусадтай хуваалцахгүй байх байгууллага хоорондын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана. Гамшгийн үед төрсөн хүүхэд албан ёсны иргэний бүртгэлгүй байх магадлалтай тул хамгааллын илүү өндөр эрсдэлтэй гэдгийг тооцоолно. Хүмүүнлэгийн баг, хамт олон нь хамгааллын, ялангуяа хүүхэд хамгааллын дүрэм журмыг баталж мөрдөх, болзошгүй зөрчлийг мэдээлэх, засаж залруулах журамтай байна.

Зургаадугаар зарчим. Хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн тусламжийг ялгаварлан гадуурхалтаас ангид, шударгаар үзүүлэх

Хүмүүнлэгийн ажилтан нь тусламжийг хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлж, ялгаварлан гадуурхалтаас ангид олгоход анхаарч хүүхэд, гэр бүлийг үндсэн хэрэгцээгээ хангахад нь учирч буй саадыг арилгахын тулд хүмүүнлэгийн зарчим, холбогдох хуулийг мөрдөнө. Ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлын шинж тэмдэг илэрсэн үед хүмүүнлэгийн баг нөхцөл байдлыг тухай бүрд нь засаж залруулах арга хэмжээг авч тусламжийг гамшигт нэрвэгдсэн хүн амд тэгш, шударгаар үзүүлж, хүртээнэ.

Долоодугаар зарчим. Бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл, сүрдүүлэг, албадлага болон санаатайгаар бий болгосон хомсдолыг даван туулахад нь туслах

Хүмүүнлэгийн ажилтан эрх нь зөрчигдсөн хүмүүст шууд, тасралтгүй тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд тэднийг нэмэлт үйлчилгээнд хамруулна. Уг зарчмын хүрээнд гамшигт нэрвэгдсэн хүн амыг хүчирхийлэл, албадлага, хомсдолд нэмж орохоос урьдчилан сэргийлж, аюулгүй байдал, нэр төр, эрхээ хамгаалах хүүхдийн өөрийнх нь хүчин чармайлтыг дэмжинэ. Бүх байгууллага хүүхдийн аюулгүй байдалд илүүтэй анхаарч, аюулгүй байдлаа хангах, эрсдэлийг бууруулах хүүхэд, түүний гэр бүлийн өөрсдийнх нь хүчин чармайлтыг дэмжинэ.

Наймдугаар зарчим. Хүмүүст эрх ашгаа хамгаалахад нь туслах

Хүмүүнлэгийн ажилтан нь гамшигт нэрвэгдсэн хүн амд мэдээлэл өгч, баримтжуулан тэдэнд эрх ашгаа хамгаалахад нь тусалж, хүний эрхийг хүндэтгэн үзэх хүчин чармайлтыг дэмжинэ. Хүүхдэд эрхээ эдэлж, засгийн газар болон бусад эх үүсвэрээс тусламж үйлчилгээ авахад нь туслахын тулд дараах алхмыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мэдээллээр хангах,
- Бичиг баримтжуулах (төрсний гэрчилгээ, үрэгдүүлсэн баримт бичгээ сэргээлгэх, олж авахад нь гэр бүлд дэмжлэг үзүүлэх гэх мэт),
- Шийдлийг олоход нь туслах.

Хүүхэд хамгааллын болон хүмүүнлэгийн ажилтан бусад хүмүүс (эцэг эх, асран хамгаалагчид) хүүхдийн нэрийн өмнөөс хүсэлт гаргаж эрх ашгаа хамгаалахад нь тусална. Хуулийн туслалцаа авч өөрсдийн эрхийг хамгаалуулах (тухайлбал өв залгамжлах, нөхөн төлбөр авах гэх мэт) боломжоор хангах нь хүүхдийн өөрийгөө хамгаалах, бусад эрхээ эдлэхэд нь нөлөөлнө. Хүүхдийг мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд оролцуулж идэвхтэй иргэн байхыг дэмжинэ. Ингэснээр хүүхэд:

- Эрхээ мэддэг
- Оролцооны аргад суралцсан
- Мэдээллийг олж авах, ашиглах чадвартай
- Бусадтай харилцаатай
- Засгийн газрын үүрэг хариуцлагыг мэддэг болно.

Есдүгээр зарчим. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх

Гамшгийн үеийн хариу арга хэмжээний явцад хүүхэд хамгааллын тогтолцоонд байгаа давуу талыг илрүүлж цаашид бэхжүүлнэ. Харин хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулахын тулд тогтолцоонд суурилсан арга аргачлалыг идэвхжүүлж асуудалд суурилсан ажиллагаанаас зайлсхийнэ. Хүүхдэд тулгарч буй асуудлыг олон талаас нь шалтгаан, шийдлийн хамт авч үзэхийн тулд тогтолцооны дараах аргачлалыг ашиглана. Үүнд:

- Асуудлыг эх үндэс, суурь шалтгааныг илрүүлэх;
- Хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулах;
- Орон нутгийн иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих;
- Салбар дундын хамтын ажиллагааг хангах;
- Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зэрэг хэрэгжүүлэх;
- Холбогдох бүх талуудтай хамтран ажиллах

Хүмүүнлэгийн нөхцөл байдалд үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж шинэлэг аргыг хэрэглэнэ. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж хүүхдэд хүрэх үр нөлөөг сайжруулна. Тогтолцооны албан болон албан бус хэлбэрийн уялдаа холбоог хангана. Үүнд, цагдаа, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, халамжийн ажилтан, боловсролын ажилтан, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэргэжилтэн, насанд хүрээгүй хүүхдийн хууль эрх зүйн мэргэжилтэн болон сэтгэцийн эрүүл мэндийн ажилтан оролцоно.

Аравдугаар зарчим. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үед хүүхдийн даван туулах чадавхыг бэхжүүлэх

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн өөрийнх нь чадавхыг бэхжүүлж, эрсдэлийг бууруулах буюу таслан зогсоож, эрсдэлийг даван туулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх юм. Хүүхдийн оролцоог хангах нь түүний даван туулах чадварыг бэхжүүлдэг. Хүүхдийн оролцоотой хүмүүнлэгийн хөтөлбөр нь гамшиг, онцгой байдлын үеийн

Цар тахлаас ч өмнө байсан хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдал, мөлжлөгийн асуудал цар тахлын нөлөөгөөр улам гүнзгийрч, улс орон, бүс нутаг, гэр бүл, хувь хүний сайн сайхан байдалд хор уршиг учруулсаар байна (М.Чанцалсүрэн, 2021; НҮБ, 2022). Тухайлбал, Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн цар тахлын эсрэг арга хэмжээ нь хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндээс гадна нийгэмшихүйн хөгжилд сөргөөр нөлөөлсөөр байна. Дэлхий дахинд хүүхэд хамгаалалд, ялангуяа хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг нэн түрүүнд анхаарахыг НҮБ-ын Хүүхдийн сангаас уриалж байгаа билээ (НҮБХС, 2021). Гамшгийн онцгой нөхцөл байдлын улмаас бүх шатны боловсролын байгууллага цахим орчинд шилжсэнээр боловсролын байгууллагаар дамжуулан илэрдэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэх байдал “тэг зогсолт” буюу энэ төрлийн мэдээллийн суваг бүрэн хаагджээ (М.Чанцалсүрэн А. Б., 2022). Энэхүү цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хүүхдийн хамгаалуулах эрхэд сөргөөр нөлөөлсөн төдийгүй гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг судлах, сайжруулах шаардлагатайг харууллаа. Хүүхдэд тулгарч буй эрсдэлт хүчин зүйлсийн давтамж нэмэгдэх тусам хүүхдийн эрх нь зөрчигдөх магадлал улам бүр нэмэгдэж байдаг. Учир нь энэхүү эрсдэлт хүчин зүйлсийг хамгаалах хүчин зүйлсээр саармагжуулах, хүүхдийн эмзэг байдлыг бууруулахад тухайлсан арга хэмжээ авахгүй бол дээрх асуудал хожим арилшгүй хор хохирол учруулдаг байна (Johnson, 2004). Гамшгийн үед хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж хамгаалахын тулд хүүхдийн эрсдэлд өртөмтгий эмзэг байдлыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий олон салбарын уялдааг ханган ажиллах нь хүүхэд хамгааллын үйлчилгээний амин чухал хэсэг юм.

Хэрэв бид гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг бэхжүүлэхийн тулд гамшгийн үеийн эрсдэлийг бууруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн сүлжээ болон дэмжлэг үзүүлэх тогтолцоо, олон салбарын хамтын ажиллагааг тогтмол сайжруулах зэргээр урьдчилан сэргийлж, системтэй хөрөнгө оруулалтыг хийснээр гамшгийн үеийн хүүхэд хамгааллын ирээдүйн өгөөжийг нэмэгдүүлж, хөрөнгө нөөцийг хэмнэн, гамшгийг бүхий л түвшинд тэсвэртэйгээр даван туулах чадавхыг бэхжүүлж чадна.


1.3

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

Нийгэм-экологийн загвар. Нийгэм-экологийн загварыг гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежментэд түгээмэл ашигладаг. Энэ загварыг К.Гарбарино, К.С.Бельский нар Америкийн эрдэмтэн У. Брофенбрэннерийн (Urie Bronfenbrenner) хүний хөгжлийн экологийн онолд суурилж хүүхэдтэй зүй бус харилцахад нөлөөлөх эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсийг нийгмийн бүх түвшинд авч анх үзсэн нь хүүхэд хамгааллын практикт хамгийн түгээмэл хэрэглээтэй загвар болсон (Батхишиг, 2019). Нийгэм экологийн загварт хүрээлэн буй орчин буюу хүмүүн хоорондын харилцаа, олон нийт, орон нутаг, нийгэм нь хүүхдийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн тухайн нөхцөл байдал, нийгэм соёлын орчин нь хоорондоо хэрхэн харилцдаг, ямар уялдаа холбоог байгааг ойлгоход тусалдаг.

Нийгэм экологийн загварыг ашиглан хүүхдийн ахуй орчноос нийгэм-соёлын түвшин хүртэлх макро системд тухайн хүүхдийн эрх зөрчигдөх эрсдэл өндөр байгаа эсэх, хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, зөв үр дүнтэй хамгааллын менежментийг тодорхойлохын тулд хүүхдийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсийг ойлгож мэдэх боломж олгодог (UNHCR, 2019). Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх хувь хүн, гэр бүл, олон нийт, нийгмийн хүчин зүйлсийн харилцан уялдааг тодорхойлоход нийгэм экологийн загварыг ашигладаг.

Зураг 3. Нийгэм экологийн загвар



Хувь хүн - Хүүхдийн нас, хүйс, сэтгэцийн эрүүл мэнд, зан байдлын эмгэг, хөгжлийн бэрхшээл, төрийн бодлого, хууль тогтоомж

Харилцаа - Гэр бүлийн гишүүдтэй харилцах харилцаа, найз нөхөд, хамтрагч, ойр дотнын нийгмийн хүрээлэл

Олон нийт - Хөрш, саахалт айл, мэдээ мэдээлэл, сургууль, ажлын орчин, хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээ сул байх, нийгмийн болон шашны байгууллага, биет орчинтой холбоотой хүчин зүйлс

Нийгэм - Нийгмийн тэгш бус байдал, хүчирхийллийг дэмжсэн эрх зүйн, соёлын хэм хэмжээ, зөрчил мөргөлдөөн, байгалийн гамшгийн дараах хүнд нөхцөл байдал

Зураг 3-т буй хувь хүүхдийн өдөр тутмын амьдралд нөлөөлж байдаг нийгэм, орон нутаг, оршин суугаа газар орон, гэр бүл, харилцаатай хүмүүс, хувь хүний онцлог шинж, хүчин зүйлс нь өөр хоорондоо харилцан нөлөөлж байдаг. Хувь хүний ахуй орчноос нийгмийн түвшин хүртэлх бүхий л нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, хамгаалах хүчин зүйлсийг дэмжих замаар тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог.

Эрсдэлт ба хамгаалах хүчин зүйлс. Гамшгийн үе дэх хүүхэд хамгааллын менежментэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хамрах хүрээ, хамгаалах болон эрсдэлт хүчин зүйлсийг ойлгож мэдэх нь чухал юм. Эрсдэлт хүчин зүйлс нь тухайн хүүхдийн ахуй, орчин нөхцөлөөс давсан, өргөн хүрээний буюу мезо болон макро түвшинд учирч буй бэрхшээл саадыг илэрхийлдэг. Энэ нь бие махбод, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны үйл явцын нэг хэсэг болж хувь хүний тодорхой зан чанартай харилцан үйлчилж, хүүхдийн эрхийг зөрчих магадлалыг нэмэгдүүлнэ. Хамгаалах хүчин зүйлс нь хувь хүн, олон нийт, нийгмийн давуу тал, онцлог, нөөц, боломжид тулгуурлан тэдэнд тулгарах аливаа эрсдэлээс сэргийлэх, учирсан бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэх хүчин зүйлс юм (UNHCR, 2019; Батхишиг, 2019).

Зураг 4. Эрсдэлт ба хамгаалах хүчин зүйлс



Эх сурвалж: UNHRC. (2021). Your guide to protection case management. p.7

Зураг 4-т хамгаалах хүчин зүйлс ба эрсдэлт хүчин зүйлст ямар, ямар хүчин зүйлс орох, хамгаалах хүчин зүйлст тулгуурлан хувь хүнд давуу талыг хэрхэн бий болгохыг дүрслэн харуулсан. Гамшгийн үед хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ хувь хүний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хамгаалах хүчин зүйлсийг дэмжих замаар бэрхшээлийг үйлчлүүлэгчийн оролцоотойгоор хамтран шийдсэнээр хувь хүн өөрт байгаа нөөц боломжоо тултал ашиглан өөрийн төлөө шийдвэр гаргах чадвартай болдог.

Хувь хүний түвшин дэх эрсдэлийн хүчин зүйлст тухайн хүний нас, хүйс, зан байдал, хөгжлийн бэрхшээл, оюуны хөгжил, танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол, сэтгэцийн эмгэг, архи, тамхи, мансууруулах хорт бодисын хэрэглээ, хамаарал, хүчирхийлэл гэх мэт хүчин зүйлс багтдаг. Энэхүү хэв шинж нь нийгэм, соёлын хүлээлтээс үүдэлтэйгээр нийгмийн бүтцийг бий болгож байдаг (UNHCR, 2019). Хувь хүн бүр зан чанар, туршлага, угсаа гарал, нийгмийн байдал,

итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа, мэдээлэл авах бичиг үсгийн чадвар, харилцаа холбоо, эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөнд оролцогч гэх мэт олон ялгаатай шинж чанараас бүрдсэн байдаг. Хүүхэд бүр ялгаатай байдлаас үүдэлтэй хүчин зүйлсийг ямар нэг хэмжээгээр өөртөө агуулдаг. Эдгээр хүчин зүйлс нь хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулж байна уу эсхүл хамгаалах хүчин зүйлс болж байна уу гэдгийг хүүхдийн ахуй буюу хүрээлэн буй орчин, хүн хоорондын харилцаа, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, хувь хүний эрсдэлт хүчин зүйлс хувь хүний өөрийн зан чанар, нөхцөл байдалд байна уу, биет хүрээлэн буй орчинд нь байна уу, хүүхдийн нэр хүнд, эрхийг зөрчсөн байна уу, хүүхдийг хамгаалах нөхцөл

байдал харилцаанд байна уу гэх мэтээр яг хаана байгааг илрүүлэх нь чухал байдаг. Үүний үр дүнд хүүхдэд байгаа эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлийг таньж илрүүлэх боломжтой болно. Түүнчлэн хүүхдийн гэр бүлийн гишүүд, төрөл садан, сургуулийн хамт олон, найз нөхөд зэрэг хүн хоорондын харилцаанаас эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлс улбаалж байдаг. Найз нөхөд, төрөл садны тусламж дэмжлэг нь хямралын үед хамгаалах хүчин зүйл болдог бол, гэр бүлээс тусгаарлагдах, эсхүл архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг нь хүүхдийг эрсдэлд оруулах хүчин зүйл болдог.

Орон нутаг гэдэгт гэр бүл, хүүхдийн амьдарч буй эргэн тойрны сургууль, урлаг, спортын төв, дэлгүүр хоршоо, эмнэлэг, үзвэр үйлчилгээний газар гэх мэт биет байгууламж багтдаг. Нэн шаардлагатай нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд орон нутаг хамгийн чухал үүрэгтэй. Орон нутагт түшиглэсэн хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд оролцоонд тулгуурлан хүрээлэн буй орчны олон талын дэмжлэг, нөөц, боломжоор дамжуулан саад бэрхшээлийг хамтдаа шийдвэрлэх замаар хүүхэд, гэр бүлийг хөгжүүлэхэд анхаардаг (Солонго, 2010).

Нийгмийн түвшин дэх эрсдэлт хүчин зүйлд хүчирхийллийг дэмжсэн хандлага, хүлээн зөвшөөрсөн орчныг бий болгож буй хууль эрх зүй, нийгмийн хэм хэмжээ ордог. Тухайлбал, эдийн засаг, жендэр, нийгмийн тэгш бус байдлыг хөхиүлэн дэмжсэн төрийн бодлого хууль тогтоомж, нийгмийн хамгааллын тогтолцоо, эдийн засгийн хямрал, засаглалын манлайлал сул, хууль сахиулах байгууллагын чадавхгүй байдал зэрэг хүчин зүйлс багтана. Мөн түүнчлэн, нийгэм экологийн ялгаатай түвшин дэх хүчин зүйлс өөр хоорондоо харилцан холбогдож, бие биедээ нөлөөлж байдаг тул нэгийг нь нөгөөгөөс салган, чухалчлан үзэх боломжгүй юм.

1.4

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Хүүхэд харах хөтөлбөр. Гамшгийн үеийн хямрал нь хүүхдийн нийгэм сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжилд сөргөөр нөлөөлөхөөс гадна эмзэг өртөмтгий байдлыг өдөөж байдаг. Улс орны нийгэм, эдийн засаг, соёл, хэл, онцгой байдлын байгууллагын чадавх, үйлчилгээний хүртээмж, байгаль орчин нөхцөл байдал, тухайн орон нутгийн нөөц, гээд олон хүчин зүйлс нь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээнд нөлөөлнө (Сфер Холбоо, 2018). Гамшгийн нөхцөлд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ нийгэм сэтгэл зүйн байдал, танин мэдэхүйн хэрэгцээг хангах чадавх, цаг боломж байдаггүй. Дийлэнх тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч нь гамшгийн үед тохиолдсон сэтгэл санааны хямрал, стрессийн улмаас сэтгэл санааны тэнцвэртэй байдлаа алдаж, хүүхдээ үл хайхарч, хүчирхийлэлд өртөх байдлыг нэмэгдүүлдэг. Нөгөө талаас гамшгийн улмаас нийгэм, эдийн засгийн хор учруулсан хор уршиг их, хамрах хүрээ өргөн байх тусам хүүхэд аюулд өртөх магадлал өндөр байдаг. Тиймээс гамшиг хямралд өртсөн бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэм сэтгэл зүйн хөгжлийг хамгаалахын тулд хүүхдэд ээлтэй орон зайд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах зайлшгүй хэрэгцээг хангах нь чухал (UNICEF, 2022). Хүүхэд харах үйлчилгээ нь хүмүүнлэгийн хямралын үед эрүүл мэнд, хүнсний хангамж, хоол тэжээл, усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй (WASH), хүүхдийн хөгжил, боловсролын үйлчилгээг үзүүлэхэд тогтолцооны хэсэг болдог

тул чухал ач холбогдолтой (UNICEF, 2022). Хүүхэд харах хөтөлбөр нь дараах таван үндсэн иж бүрдэлтэй. Үүнд:

1. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө,
2. Сэтгэл зүйн гэмтэлд суурилсан үйлчилгээ,
3. Хүүхдийн тоглох, амрах, чөлөөт цагаа өнгөрөөх, суралцах нөхцөлийг хангасан аюулгүй орчин, хөтөлбөр,
4. Хүнс хоол тэжээл, усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй, эрүүл мэнд ба нийгмийн цогц үйлчилгээ,
5. Эцэг эх, асран хамгаалагчийг дэмжих, чадавхжуулах хөтөлбөр

НҮБХС-аас гэнэтийн гамшгийн үед дээрх таван иж бүрдлийг хангасан “гамшгийн үеийн хүүхэд харах үйлчилгээний байрны гурван хэлбэрийг санал болгодог бөгөөд гамшгийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төрөл, хэлбэрийг сонгоно (UNICEF, 2022).

1. **Хүүхэд харах явуулын үйлчилгээ:** Энэтхэг, Буркина Фасо, Руанда улсад автобус эсхүл том оврын ачааны тээврийн хэрэгслийг явуулын хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар тоноглон тохижуулж, дүрвэгсэд эсхүл хүрэхэд хэцүү газар нутагт амьдарч буй хүн ам, хүүхдэд хүрч бага насны хүүхэд асран халамжлах, хамгаалах үйлчилгээг үзүүлж, сургалт зохион байгуулдаг.
2. **Хүүхэд харах үйлчилгээний цэг:** Гэнэтийн гамшиг хямралын үед хүүхэд харах хөтөлбөр ховор хэдий ч, хүмүүнлэгийн байгууллагын хүчин чармайлтын үр дүнд хүүхэд хамгааллын сайн туршлага олон бий. Эдгээр нь хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орон зайг хэрхэн хурдан шуурхай барьж, цогц үйлчилгээ үзүүлэхийг санал болгодог. Үүний нэг жишээ болох “Цэнхэр цэг” үйлчилгээний талаар Шигтгээ 2-д дэлгэрэнгүй тайлбарласан.
3. **Гэрт түшиглэсэн хүүхэд харах үйлчилгээ:** Гэрт түшиглэсэн хүүхэд харах үйлчилгээ гэдэг нь хүүхэд харагч нь өөрийнхөө гэрт эсхүл хүүхдийн гэрт хүүхэд харах үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ. Гэнэтийн гамшиг, онцгой байдлын үед гэрт түшиглэсэн хүүхэд харах үйлчилгээ үзүүлэхэд төвөгтэй асуудал тулгардаг. Тиймээс хүүхэд харах бусад хувилбарт үйлчилгээг сонгох нь чухал байдаг.



Шигтгээ 2. “Цэнхэр цэг” гамшиг, хүмүүнлэгийн үеийн хүүхэд харах үйлчилгээ

НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн комиссар, орон нутгийн засаг захиргаа, түншүүдтэй хамтран Украин дахь дайнаас дүрвэж буй гэр бүлүүдэд туслах “Цэнхэр цэгүүд” байгуулсан нь (UNICEF, 2022) дотоодын хямралын улмаас эх орноосоо дүрвэсэн Сири хүүхдүүдэд хамгаалах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх “Цэнхэр цэг”-ийг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагаас үүдэлтэй.

Дайны улмаас нутаг орноосоо дүрвэсэн Украин хүүхэд бүр хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний наймаанд өртөх эрсдэл өндөр тул тухайн хүүхдүүдэд аюулгүй, тогтвортой, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Ялангуяа харгалзах хүнгүй, эсхүл гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдэд ийм үйлчилгээ нэн шаардлагатай юм.

НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн комиссар, түншүүдтэй хамтран байгуулсан “Цэнхэр цэг”-үүд нь аюулгүй, хамгаалагдсан орон зайг бий болгож, хүүхэд, гэр бүлд тус дэм болох бодит дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангадаг. “Цэнхэр цэг” нь харгалзах хүнгүй хүүхэд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЖСХ-ийн хохирогчдод нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээг үзүүлдэг.

“Цэнхэр цэг” нь хүүхдэд ээлтэй өрөөг байгуулдаг бөгөөд энэ нь гэр бүл, найз нөхөд, өөрийн бүхнээ орхин, айдас түгшүүр, сэтгэл зүйн цочрол хямралтай нүүр тулж буй мөчид хүүхдэд амарч, тоглож, хүнд хэцүү нөхцөлд ч хүүхдээрээ байх таатай орчныг бий болгодог. “Цэнхэр цэг”-т ганцаараа дүрвэж буй хүүхэд гэр бүлтэйгээ эргэн нэгдэх боломжтой тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдыг бүлгийн арга хэмжээнд хамруулан, сэтгэл зүйн туслалцаа шуурхай үзүүлдэг. Түүнчлэн, “Цэнхэр цэг”-т дүрвэгсдэд зориулсан амрах өрөө, хүүхэд хөхүүлэх газар, цэвэр ус, гэр бүлийн бусад гишүүдтэй холбогдох Wi-Fi төхөөрөмж бүхий орчин болон цаашдын аяллаа төлөвлөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдаг.

Цэнхэр цэг нь тухайн орон нутгийн хамгааллын тусгай үйлчилгээнд хэрхэн хамрагдах, гэр бүлийн гишүүдтэйгээ хэрхэн уулзах талаар найдвартай, шинэ, үнэн зөв мэдээллээр хангадаг. Мэдээллийг олон сувгаар, өөр өөр хэлээр, хүүхдэд ойлгомжтой байдлаар, цахимаар авах боломжийг мөн бүрдүүлж өгсөн байдаг.

Эх сурвалж. UNICEF, 2022. Retrieved from: <https://www.unicef.org/eca/what-are-blue-dots-hubs>

“Цэнхэр цэг” нь нэн шаардлагатай үйлчилгээг нэг дороос хүргэх гамшиг, хүмүүнлэгийн үед ашиглах нэг цэгийн үйлчилгээний загвар юм. Энэ цэгт мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөгч, эрх зүйч зэрэг олон салбарын мэргэжилтнүүд хамтран, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн хамгаалал, халамжийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

Нийгмийн хамгааллын арга хэмжээний туршилтын төсөл.

Манай орны малчид байгалийн гамшгаас өөрсдийгөө хамгаалах мэдлэг, чадавх сул, гэнэтийн аюул ослоос хамгаалах бизнес эдийн засгийн таатай тогтолцоо бүрэлдээгүйгээс байгалийн гамшигт өртөж, амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүй, эдийн засгийн их хэмжээний гарз хохирол амсдаг. Түүнчлэн гамшигт нэрвэгдсэн малчдын хүүхдүүдийг эрсдэлээс хамгаалах, суурь үйлчилгээний хүртээмжийг хангахад чиглэсэн тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоогүйгээс гамшгийн өмнө ба дараа хүүхдийн нэр төрийг хамгаалах, хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд үүссэн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ орхигддог.

Хүүхдэд чиглэсэн НХАХ-ний энэхүү туршилтын төсөл нь байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотойгоор цочрол үүсэх эрсдэл өндөртэй, ялангуяа зудын өндөр эрсдэлтэй бүс нутагт амьдардаг 5 хүртэлх насны хүүхдүүдэд “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг нэмэгдүүлэх замаар байгалийн аливаа гэнэтийн цочролын сөрөг нөлөө, эрсдэлээс хүүхдийг хамгаалах зорилготой хэрэгжсэн.



Шигтгээ 3. Нийгмийн хамгааллын арга хэмжээний туршилтын төсөл 2019/2020

Бараа материалын тусламж, ваучер зэрэгтэй харьцуулахад мөнгөн дэмжлэгийн онцлог нь өрх бүр өөрийн хэрэгцээндээ тохируулан захиран зарцуулах боломжтой байсан. Иймд мөнгөн тусламжийн зарцуулалт нь өрхийн дундын хэрэглээ (өвлийн бэлтгэл хангахад шаардлагатай түлээ, нүүрс, гэрийн дулаалга гм авах)-нээс гадна шууд хүүхдийн хэрэглээ (өвлийн гутал, дулаан хувцас)-нд чиглэсэн нь төслийн үндсэн зорилго болох хүүхэд хамгааллын арга хэмжээтэй нийцсэн юм.

Олон хүүхэдтэй өрх бусад өрхтэй харьцуулахад хүнсэнд илүү их мөнгө зарцуулсан. Тухайлбал 0-5 насны 1-2 хүүхэдтэй өрхүүдийн 18% нь дэмжлэгийн мөнгийг хүнсэнд зарцуулж байхад 3 хүүхэдтэй өрхүүдийн 36-39% нь төслийн сүүлийн хоёр сарын хугацаанд мөнгөн дэмжлэгийн ихэнх хэсгийг хүнсэнд зарцуулжээ. Цөөн хүүхэдтэй айл тусламжийн мөнгийг хүүхдийн эрүүл мэнд, дархлаажуулалтад илүү зарцуулах хандлагатай байсан байна.

Эх сурвалж: ХНХЯ, НҮБХС. 2020 он. Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын туршилтын арга хэмжээний үнэлгээний тайлан, хууд.19,25

ХОЁР

ГАМШГИЙН ҮЕД ХҮҮХДЭД ТОХИОЛДОХ ЭРСДЭЛ

- 2.1 Гамшгийн үеийн эмзэг байдал, хүүхдэд тохиолдох эрсдэлийн төрлүүд
- 2.2 Гамшгийн үед хүүхдэд учирч болох эрсдэл, бэрхшээлд авах хариу арга хэмжээ
- 2.3 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын практик хэрэглээ, сайн туршлага

2.1

ГАМШГИЙН ҮЕИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, ХҮҮХДЭД ТОХИОЛДОХ ЭРСДЭЛИЙН ТӨРЛҮҮД

Гамшигт нэрвэгдэгсэд тодорхой хэмжээгээр эрсдэлд эмзэг, өртөмтгий байдаг бөгөөд ялангуяа, хүүхдэд гэнэтийн хагацал, байгалийн гамшиг гээд хямралт үйл явдал нь нэн эмзэг байдлаар тусдаг учраас хүчирхийллийн эрсдэлд томчуудаас илүү ихээр өртдөг. Хүүхэд өөрийн биеэр мэдэрч туулсан хагацал, тусгаарлалт, зэвсэгт мөргөлдөөн эсвэл бусдын эрхэнд орж зэвсэгт бүлэглэлд хүчээр элсэх, бие махбод болон бэлгийн хүчирхийлэлд өртөх, сэтгэлзүйн хямрал эсхүл сэтгэцийн эмгэгт өртөх, эдийн засгийн мөлжлөгт өртөх, өвчин эмгэг тусч, гэмтэж бэртэх улмаар амь насаа алдах зэрэг олон эрсдэлд өртдөг (Action, 2019).

Гамшгийн менежментийн гарын авлага, удирдамжид хүүхдэд туслах үйл ажиллагааг ихэвчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй нь холбож, тэднээр дамжуулах нь хамгийн сайн үр дүнтэй байдаг гэж үздэг. Ер нь хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн амын нэг ангилал болгон ойлгосоор ирсэн нь хүүхдийн эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байгаа юм.

- Хүүхэд нас, биеийн хөгжлөөс шалтгаалж эцэг эхээсээ маш их, зарим үед бүрэн хамааралтай байж болно.
- Тэдний өдрийн хуваарь өрхийн доторх насанд хүрэгчид ялангуяа эхийнхээ ажилтай нягт холбогддог.
- Хүүхдүүд хэдий гамшгийн тухай мэдлэгтэй байсан ч туршлага дутах явдал түгээмэл байдаг.

Хүүхдийг Ивээх Сан нь гамшиг, онцгой байдлын үед хүүхдэд учирч болох эрсдэл, бэрхшээлүүдийн тэргүүлэх 5 чиглэлийг тодорхойлсон байдаг. Үүнд:¹⁴

1. Гэр бүлээс хагацах, тусгаарлагдах
2. Мөлжлөг, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болох
3. Бие махбодын хохирол амсах, осол гэмтэлд өртөх
4. Нийгэм сэтгэл зүйн хямралд өртөх
5. Зэвсэгт хүчин, зэвсэгт бүлэглэлд татагдах

1. Гэр бүлээсээ хагацах, тусгаарлагдах: гамшиг онцгой байдлын үед хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээсээ шууд эсвэл дам хамааран хагацах, салах, төөрөх эрсдэлд орох магадлал ихэсдэг. Тиймээс гэр бүлээсээ хагацсан хүүхдийг олж илрүүлэх, гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нь хайж олох, тогтоох, эргэн нэгтгэх нь нэн тэргүүнд авах шаардлагатай арга хэмжээнүүдийн нэг байдаг. Мөн хоёрдогч хагацлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг давхар авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

2. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх: энэ төрлийн хүчирхийлэл, мөлжлөг нь гамшиг, онцгой байдлын үед бүр ч их нэмэгддэг. Үүний зэрэгцээ хүүхэд хамгаалал, дэмжлэг тусалцааны

14 ХИС, Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага, 2017

үйл ажиллагаа хязгаарлагдмал болдог. Гамшиг, онцгой байдлын үеэр бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт хөвгүүд, охид өртөх нь ихсэж, насанд хүрэгчдийн зүгээс ирэх дарамт доромжлол, эрт гэрлэлт, хил дамнуулан худалдах гэх мэт гэмт хэргийн хохирогч болох гэх зэргээр хавсарга байдлаар эрсдэл ихтэй болж ирдэг.

3. Бие махбодын хохирол амсах, осол гэмтэлд өртөх: гамшиг, онцгой байдлын үед гамшгийн аюулаас үүдэлтэй хохирлоос гадна түүнээс үүсэх бие махбодын хохирлыг хүүхдүүд амсах эрсдэлд байнга өртдөг. Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөний уршгаар хүүхдүүд эрэмдэг болох, амь насаа алдах ч тохиолдол гарна. Мөн зөвхөн гамшиг, ослоос үүдэлтэй гэмтэл, бэртэл авахын зэрэгцээ хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн амсаж байгаа сэтгэл санааны хүнд дарамт нь зүй бус харьцаа буюу үл хайхрал, дарамт, хүчирхийлэл, шийтгэл болон хүүхдэд тусах нь бас бий.

4. Нийгэм, сэтгэл зүйн хямралд өртөх: гамшиг, онцгой байдлын үед хүүхдүүд олон төрлийн бэрхшээл, хүнд нөхцөл байдалтай тулгардаг бөгөөд дийлэнх нь хүүхдийн давж туулах чадвар, боломжоос хэтэрсэн байдаг. Энэ үед хүүхэд хүүхдэд ээлтэй орчинд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамт олныхоо дунд байж, тэдний тусламж дэмжлэгийг авснаар, сэтгэлийн дарамт, хямралыг эерэг байдлаар даван туулах боломж бүрддэг.

5. Зэвсэгт хүчин, зэвсэгт бүлэглэлд татагдах: энэ төрлийн асуудал бэрхшээл манай улсад тохиолдоод байдаггүй ч дэлхийн өнцөг булан бүрд янз бүрийн шалтгааны улмаас өрнөсөн дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр болон “сайн дур”-аар татан оролцуулах байдал цөөнгүй тохиолддог. Энэ нь хүүхдийг хамгийн ихээр эрсдэлд оруулдаг. Хүүхэд зэвсэгт тулаанд өөрөө зэвсэг барин оролцох, тагнуул хийх, мэдээ хүргэх, тогооч, үйлчлэгч хийх, мөн бусад цэрэг, босогчдын бэлгийн мөлжлөгт өртөх байдал тэднийг амиа алдах, бие махбодын гэмтэл авах, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх, сэтгэл санааны гүн хямралд оруулах аюултай. Ийм байдалд орсон хүүхэд эргээд энгийн амьдралд орохдоо маш олон бэрхшээлтэй тулгардаг байна.

Дээрх дурдсан хүүхдэд тулгарч болох үндсэн таван бэрхшээлээс гадна гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн эмзэг байдалд нөлөөлөх олон хүчин зүйлүүд ихэсдэг. Үүнд:

- Хоол, хүнсний хомсдол
- Агаар, усны бохирдол
- Орон байрны хомсдол
- Ядуурал

Хоол, хүнсний хомсдол: ялангуяа бага, өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, өсөлтөд ноцтой нөлөөлнө. Жирэмсэн эхчүүдийн эрүүл мэнд, үр хөврөлд муугаар нөлөөлж, төрөх хүүхдийн жин багасах, өлөн, хоол муутай эх хүүхдээ хөхөөр зөв хооллох боломжгүй учраас нярай хүүхдийн эрүүл мэндийг эрсдэлтэй болгодог. Ерөнхийдөө гамшиг онцгой байдлын үед хүүхдүүд уургийн дутагдал, тэжээлийн хомсдолд нэрвэгдэх явдал түгээмэл байдаг.

Агаар усны бохирдол: хүүхдүүд пестицид, хар тугалга, улаан мөнгөн ус зэрэг бохирдуулагч бодисуудыг биеийн жинтэйгээ харьцуулахад ихээр шингээж авдаг учраас маш эмзэг байдаг. Агаар, усны бохирдол гамшиг онцгой байдлын дараа түгээмэл тархдаг тул үүнээс үүсдэг халдварт өвчний гол нэрвэгдэгч нь хүүхдүүд болдог.

Орон байрны хомсдол: үүссэн нөхцөл байдлын улмаас орон гэргүй болсон хүүхдүүд нүүлгэн шилжүүлсэн хорогдох байранд ахуйн хэрэглээний наад захын шаардлага хангахгүй орчинд

тогтохгүй тэнүүчлэх, янз бүрийн дарамт шахалтад (үндэстэн ястан, шашин, нийгмийн давхарга, хүйс г.м.) орох явдал ихсэж, тэр хэрээр тэдний эмзэг байдал нэмэгддэг.

Ядуурал: амьжиргаа нь гамшиг онцгой байдлын улмаас сүйрсэн ядуу айл өрхүүд орлого олуулахаар хүүхдээ сургуулиас гаргах, ажил хийлгэх явдал түгээмэл тохиолддог. Гамшгийн дараах хомсдолын улмаас хүүхдүүд хүнд хүчир хөдөлмөр эрхлэх, боолчлогдох, жендэрээс үүдэлтэй бэлгийн хүчирхийлэлд өртөх, хил дамнуулан худалдагдах зэргээс гэмт хэргийн золиос болох нь элбэг болж, өсөх хандлага ажиглагддаг.

2.2

ГАМШГИЙН ҮЕД ХҮҮХДЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, БЭРХШЭЭЛД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн үед хүүхдэд учирч болох эрсдэл бэрхшээлд нэн даруй эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авснаар гамшиг ослын сөрөг нөлөөг төдий чинээгээр бууруулж чадна. Тиймээс өмнөх бүлэгт дурдсан үндсэн таван бэрхшээл, эрсдэл тус бүрд авах хариу арга хэмжээний талаар доор тусгаж өглөө. Үүнд:

1. Гэр бүлээсээ хагацах, тусгаарлагдах. Гамшгийн нөхцөл байдлын үед хүүхэд санамсаргүй байдлаар эцэг эх, асран хамгаалагчаасаа салах, тусгаарлагдах, орхигдох, хулгайлагдах, өнчирч үлдэх гэх мэт тохиолдол гардаг. Зарим хүүхдүүд эцэг эхээсээ хагацаж, салсан ч ах дүү хамаатан садантайгаа үлдэх тохиолдол байхад заримдаа хэн нэгний халамж, анхааралгүй орхигдох тохиолдол байдаг. Хүүхэд хараа хяналтгүй удаан байх тусам гэр бүлтэйгээ эргэн нэгдэх боломж нь буурч улмаар хүчирхийлэл, мөлжлөгт өртөх нь ихэсдэг. Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийг аль болох гэр бүлийн гишүүдтэй нь хамт байлгах, тусгаарлагдаж, орхигдсон тохиолдолд гэр бүлтэй нь эргэн нэгтгэх ажлыг хийх нь чухал юм. Хүүхэд гэр бүл, хамаатан садан, асран хамгаалагчтайгаа хамт байх боломж бүрдээгүй тохиолдолд асрамж халамжийн газар шилжүүлж, аюулгүй орчинд халамжлан, хамгаалах арга хэмжээг авах хэрэгтэй. Хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчтай нь хамт байлгахын тулд дараах зүйлд анхаарч ажиллана:

- *Гамшгийн нөхцөл байдал, нүүлгэн шилжүүлэлтийн үед хүүхдийг аль болох эцэг эх, асран хамгаалагчаас нь салгахгүй байх.* Олон нийтийг хамарсан үймээн самуун болон нүүлгэн шилжүүлэлтийн үед хүүхдэд өөрийнх нь талаар мэдээлэл бүхий бугуйвч зүүж өгөх, сургууль, цэцэрлэгийн хувьд тухайн хүүхэдтэй холбоотой мэдээллийг урагдахааргүй цаасан дээр бичиж цүнхэнд хийж өгөх, өөрт нь цээжлүүлэх гэх мэтээр урьдчилан сэргийлэх ажлыг хийх боломжтой. Тухайн мэдээлэлд хүүхдийн овог нэр, гэрийн хаяг, сургууль, цэцэрлэгийн талаарх мэдээлэл байхаас гадна боломжтой бол холбогдох утасны дугаарыг бичсэн байна.
- *Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдүүдийг хэрхэн олох талаар орон нутгийн иргэдийг сургах.* Тухайлбал, үйлчилгээний байгууллагууд, орон нутгийн иргэдтэй уулзаж орхигдсон болон хараа хяналтгүй явж буй хүүхдийг хэрхэн таньж мэдэх, хэрхэн мэдээлэх талаар сургах, мэдээллээр хангах, мэдээлэх сүлжээ, сувгуудыг бий болгож ажиллах нь зүйтэй юм.

- *Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдүүд болон тэдэнд тохиолдож болох эрсдэлийн талаар урьдчилсан байдлаар мэдээлэл цуглуулах.* Хүүхэд яагаад ямар учраас хэрхэн эцэг эхээсээ тусгаарлагдан үлддэг талаарх учир шалтгааныг судалж улмаар урьдчилан сэргийлэх үүднээс хүүхэд болон орон нутгийн иргэдтэй мэдээлэл солилцох, сургалт, сурталчилгааны ажил хийх хэрэгтэй.
- *Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдүүдийг гэр бүлтэй нь эргэн нэгтгэх хөтөлбөр боловсруулах.* Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдүүдийг олж тогтоох, баримтжуулах, илрүүлэх, нэгтгэх ажлыг системтэйгээр хийх хөтөлбөр боловсруулж, оролцогч талуудыг сургах.
- *Төрийн болон хүүхэд хамгааллын бусад байгууллагууд нэгдсэн нэг стандарт бүхий бүртгэлийн маягттай байх хэрэгтэй.* Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдийг олж илрүүлэхийн тулд тухайн хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчийн талаарх хэрэгтэй мэдээллийг агуулсан маягттай байх. Мэдээлэл авахын тулд хүүхэд, тэдний эцэг эхтэй аль болох нэг удаа уулзаж, шаардлагатай мэдээллийг нэг дор ярилцаж авахаар зохион байгуулах.
- *Гэр бүлтэйгээ нэгдэх боломжийг дэмжих тусгай төвүүдийг нээн ажиллуулах.* Энэ тохиолдолд аль болох олон хүний мэдэх танил газруудыг сонгох нь чухал. Хүүхдүүд болон эцэг эхчүүд бие биеэ амархан олох, эсвэл хаанаас олох талаар мэдээлэл авах боломжтой уулзалтын цэгүүдийг ажиллуулах хэрэгтэй. Эдгээр төвүүдийн тухай мэдээллийг түгээснээр эцэг эх, хүүхдүүд бие биеэ олох магадлал нэмэгдэнэ. Мөн эдгээр газрууд нь гэр бүл, хүүхдүүдийг аюулгүй орон байранд, хоол хүнс, сэтгэцийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах боломжтой байхаар зохион байгуулалт хийж ажиллах нь чухал юм.
- *Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээ.* Гамшиг, онцгой байдлын үед асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэд, эсвэл үл хайхрагдсан, хүчирхийлэл мөлжлөгт өртсөн хүүхэд гэсэн хоёр бүлгийн хүүхдийг хүлээн авах асрамж халамжийн хувилбарт үйлчилгээг үзүүлнэ (СХЗГ, 2021).
- *Түр хугацаагаар асрамжид байгаа хүүхдүүдийг хуулийн хүрээнд халамжлан асрах.* Хэрэв хүүхдийг хамаатан садны асаргаанд хүлээлгэн өгөх бол тухайн насанд хүрсэн асран хамгаалагч хүүхэд асран хамгаалах хариуцлага хуулиар хүлээх ёстой. Асран хамгаалагчаас хүүхэд асран хамгаалах хариуцлага хүлээж байгаагаа бичгээр гаргаж өгөх бөгөөд энэ тохиолдолд асран хамгаалагч хүүхдийн аюулгүй байдал болон аливаа асуудал тулгарсан үед мэдээлэх үүргийг давхар хариуцна.

2. **Жендэрт суурилсан хүчирхийлэл.** Жендэрт суурилсан хүчирхийлэл нь гамшиг, онцгой байдлын үед нэмэгдэх хандлагатай байдгийг НҮБХС-гийн Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын аргачлалд өгүүлсэн байдаг. Гамшгийн үед жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг хүүхэд хамгааллын мэргэжлийн болон мэргэжлийн бус байгууллагууд хэрэгжүүлнэ. Гамшгийн үед жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тохирсон тусламж үйлчилгээг ХЭЗЭЭ, ХААНА, ХЭРХЭН үзүүлэх үйл явцын талаар сайтар мэдээлэл, ойлголттой байх нь чухал. Ингэснээр хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний чанар, үр дүн гарна.

- *Эрсдэлтэй хүн амын талаарх мэдээллийг цуглуулах хэрэгтэй.* Тухайлбал, үндэстний цөөнх эмэгтэйчүүд, эдийн засгийн хувьд хараат, хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн талаар нарийн судалгаа мэдлэгтэй байх хэрэгтэй. Эрсдэлтэй хүн амын талаарх мэдээлэл цуглуулж оршин суугаа байршил, нөхцөл, болон тэдэнд хүрч үйлчилгээ үзүүлэх арга зам, нөхцөлийг урьдчилан судалж мэдсэн байх нь чухал.
- *ЖСХ-ийн, эрсдэлийн талаар эрсдэлт бүлэг төдийгүй олон нийтийн дунд сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах.* Телевиз, радио, нийгмийн бусад сүлжээг ашиглан

товч тодорхой мессежийг хүн бүрд хүргэх нь чухал юм.

- *ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, кейс менежментийг тодорхой болгож хэвшүүлэх.* Хохирогчийн талаарх мэдээллийг салбар дундын байгууллага, мэргэжилтнүүд хоорондоо солилцох арга замыг сайжруулснаар үйлчилгээ тусламжийг хамгийн түрүүнд шаардлагатай хохирогчдод үзүүлэх боломж нэмэгдэнэ. Мэдээлэл, лавлагаа солилцох үед хохирогч, түүний гэр бүлийн талаарх мэдээллийн нууцлалыг хүндэтгэн хамгаалах хэрэгтэй.
- *ЖСХ-ийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд сэтгэцийн эрүүл мэнд, нөхөн сэргээх болон нийгэмшүүлэх үйлчилгээ, сэтгэц, халамж, хууль зүй, аюулгүй байдлыг нь дэмжсэн дэмжлэг, зөвлөгөө, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах хэрэгтэй.*
- *Гамшгийн үед хүүхэд хамгаалал, болон хүмүүнлэгийн бусад тусламж дэмжлэг үзүүлж буй мэргэжилтэн, сайн дурын ажилтнуудад ЖСХ-ийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах хэрэгтэй.* Хүүхэдтэй шууд нүүр тулж ажилладаг хүн бүр ЖСХ-ийн талаарх сургалтад хамрагдаж ёс зүйн дүрэмтэй танилцсан байх шаардлагатай.

3. Бие махбодын хохирол амсах, осол гэмтэлд өртөх. Гамшиг, онцгой байдлын үед хүүхдэд осол гэмтэлд өртөхгүй байна гэх баталгаа байдаггүй. Хүүхэд гэмтэж осолдсон үедээ яаралтай тусламж авч чадаагүйгээс хөгжлийн бэрхшээлтэй болох эсвэл осол гэмтлээс шалтгаалсан хүндрэлийн улмаас амь нас эрсдэх аюултай. Гамшгийн үед хүүхдийг бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалахын тулд дараах арга хэмжээг дэс дараалалтай хэрэгжүүлдэг. Үүнд:

- *Гамшгийн үед хүүхдэд учирч болохуйц эрсдэл, эрсдэлт нөхцөл байдлын талаар аль болох дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, хүүхдийг хэрхэн хамгаалах талаар ойлголттой болох.* Гамшиг, онцгой байдлын үед хариу үйлчилгээ үзүүлж ажиллаж байгаа мэргэжилтэн нь хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, амьдарч буй орчин зэргээс шалтгаалан хүүхэд ямар гэмтэл авч болох талаар мэдлэг, мэдээлэлтэй болох нь чухал.
- *Эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүд болон хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй бүх хүмүүс гамшиг, онцгой байдлын үеэр осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэлтэй болох.* Эцэг эх, асран хамгаалагчид, хүүхдэд эрсдэлээс өөрийгөө хэрхэн зайлсхийх, хамгаалах талаар мэдлэг өгөх хэрэгтэй. Хүүхдүүд осол гэмтэлд өртсөн тохиолдолд юу хийх, хэнд, хэрхэн мэдээлэх талаар зохих ёсны мэдлэгтэй болсон байх ёстой.
- *Гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэхийн тулд сургалт, нөлөөллийн ажлуудыг идэвхжүүлэх хэрэгтэй.* Тохиолдож болох эрсдэл, тухайн эрсдэлээс хэрхэн сэргийлэх, гэмтсэн тохиолдолд юу хийж болох талаар хүүхдүүд болон тэдний эцэг эхэд зориулсан сурталчилгаа, нөлөөллийн ажил буюу мессежийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ ашиглан түгээхээс гадна сургууль болон олон нийтийн дунд уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах нь чухал юм.
- *Хүүхэд гэмтсэн тохиолдолд эмнэлгийн тусламж авахад туслах.* Гамшгаас хамгаалах онцгой байдлын мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, эмч нь гэмтэл, бэртэл авсан хүүхэд анхан шатны тусламж үйлчилгээг нэн даруй үзүүлэх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмчилгээ үйлчилгээнд нүүлгэн шилжүүлэх талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй. Хүүхдэд яаралтай анхны тусламжийг зөв, оновчтой техник, тодорхой дэс дараалалтайгаар хэрхэн хүргэх арга зүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

4. Нийгэм, сэтгэл зүйн хямралд өртөх. Гамшиг, онцгой байдлын үеийн сүйрэл, орон байр, гэр бүлээсээ холдон хагацах явдал зэрэг нь хүүхдийг сэтгэл зүйн хувьд хямралд оруулдаг бөгөөд энэ нь хүүхэд бүрд харилцан адилгүй байдлаар нөлөөлж байдаг. Гамшиг, онцгой байдлын үеийн сэтгэл зүйн хямралыг эерэг байдлаар даван туулснаар цаашид бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлж чадна. Эрүүл мэнд, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг нь гамшиг, онцгой байдлын үеийн үндсэн үйлчилгээнүүдийн

нэг юм. Эрүүл мэнд, нийгэм сэтгэлзүйн тусламж үйлчилгээний үндсэн ойлголтыг авсан хүн гамшгийн үед хүүхэд хамгааллын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж чадна.

- *Гамшгийн үед хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээг тодорхойлох.* Хүүхэд ганцаардмал болох, сурлага нь муудах, гуниг, айдастай болох зэрэг шинж тэмдгийн талаар дүгнэлт зураглал гаргаж сурах. Гамшигт өртсөн хүүхэдтэй ярилцаж тэдний мэдрэмжийг ойлгож улмаар сэтгэл зүй болон нийгмийн дэмжлэгт хөтөлбөрийг зохион байгуулж хэрэгжүүлэх
- *Гамшигт өртсөн олон нийтийн төлөөлөл болон ажилтнуудад гамшгийн нөлөөллийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.* Гамшгийн үед сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдийг таньж мэдэх, тухайн хүүхдийн асран хамгаалагч, эцэг эхэд нь юу хийх, хэнээс тусламж авч болох талаар тодорхой мессежийг өгч ажиллах хэрэгтэй.
- *Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгох.* Гамшигт нэрвэгдсэн хүүхдүүдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх боломжтой ойр дотнын хүмүүстэй аль болох хамт байлгах нь чухал. Хүүхдэд зориулсан спорт, урлагийн арга хэмжээ гэх мэт олон нийтэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулснаар хүүхэд бусадтай хамтран тоглох, эргээд өдөр тутмын хэвийн байдалдаа эргэн орох боломж нь нээгдэнэ.
- *Тухайн улсын эмгэнэл, үй гашуудлын уламжлал, зан үйл, онцлог байдлыг мэдэж хүндэтгэлтэй хандан, түүнд нь тохирсон эд зүйлсээр хангах.* Жишээ нь: Манай оронд Исламын шашинтай казак үндэстний гашуудлын ёслол өвөрмөц онцлогтой. Иймээс гашуудлын ёслолыг шашин шүтлэгийн дагуу үйлдэх боломж, нөхцөлөөр нь хангаж өгөх хэрэгтэй.
- *Хүүхдэд ээлтэй орон зайг аль болох хурдан бий болгох.* Орон гэрээсээ дайжсан, эцэг эх, асран хамгаалагчаасаа тусгаарлагдсан хүүхдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг мэдрүүлэх (тоглох, дуулах, зураг зурах, жүжиг тоглох, үлгэр ярих г.м.) боломжийг бүрдүүлсэн орон зайг бий болгох нь хүүхдийг сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангаж, нөхцөл байдлыг эергээр даван туулах боломж бүрдэнэ.
- *Нийгэм сэтгэлзүйн сэргээн засах ажлыг өргөжүүлэх, нөөцөөр хангахад анхаарлаа хандуулах.* Нийгэм сэтгэлзүйн сэргээн засах үйл ажилд хүүхэд, гэр бүл, олон нийтийг оролцуулах, дэмжих бүлгүүдийг зохион байгуулж ажиллах нь хэвийн амьдралд эргэн орох эхлэл болж чадна.
- *Мэргэжлийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах.* Сэтгэцийн гэмтэл авсан, сэтгэцийн хувьд өөрчлөлт орсон хүүхдийг дараагийн шатны сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад холбон зуучлах, эмнэлгийн тусламжид шилжүүлэх нь тухайн хүүхдийн даван туулах чадварыг нэмэгдүүлэх бөгөөд сэтгэцийн гэмтлээс илаарьшихад нь эерэг нөлөө үзүүлнэ.
- *Эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл зүйн хэрэгцээг үнэлж, дэмжлэг үзүүлэх.* Сэтгэлзүйн стресс, дарамт, айдаст өртсөн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад тусгай сургалт зохион байгуулах хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь нийгэм сэтгэлзүйн бодит үр дүн болно. Эдгээр үйл ажиллагааг хүүхэд хамгааллын байгууллагууд өөрсдийн санаачилга, нөөц бололцоог ашиглан хийх боломжтой. Хүүхэд, залуусын байгууллагатай нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх урьдчилсан гэрээг тайван цагт хийж, хамтын ажиллагааны төлөвлөгөөг бэлэн байдалд байлгах хэрэгтэй.
- *Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж болон хувь хүний нууцлалыг хамгаалсан бүртгэл мэдээллийн системийг бий болгох.* Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн тусламж үйлчилгээ шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нарт мэдээлэл өгч, хөндлөнгөөс оролцож боломжийг нь нэмэгдүүлж хамтарч ажиллах

хэрэгтэй. Эмнэлгийн тусламж үйлчилгээг анхан шатны эмнэлгийн үйлчилгээгээр дамжуулан авах боломжтой.

- *Гамшигийн үед ажиллаж буй ажилтнуудад мөн адил нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгч ажиллах нь чухал юм.* Ажилтан албан хаагчдын сэтгэл зүйг анхаарснаар сэтгэлзүйн зөвлөгөө тусламжийг тогтмол бөгөөд ёс зүйн өндөр түвшинд үзүүлэх боломж нэмэгдэнэ.

5. Хүүхдийн хөдөлмөр. Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, мөлжлөгт өртөх тохиолдол ихэсдэг. Орон гэргүй болох, ажлын байр болон тэжээгчээ алдах тохиолдолд хүүхэд хүчээр ажил хийх тохиолдол байдаг бөгөөд энэ нь тэднийг хүчирхийлэл, мөлжлөгт өртүүлж байдаг. Зөвхөн хүүхэд зөвхөн тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, эсвэл хөдөлмөрийн мөлжлөгт өртөөд зогсохгүй мөн бэлгийн мөлжлөг, боолчлол, хар тамхи, мансууруулах бодисын наймаа зэрэг хууль бус үйлдэлд өртөх магадлал давхар өндөр байдаг. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг бууруулахын тулд дараах ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй:

- *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж дүн шинжилгээ хийх.* Үнэлгээ нь албадан хөдөлмөр эрхэлж буй хүүхэд болон хөдөлмөр эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг олж илрүүлэхэд чиглэгдэх хэрэгтэй.
- Төрийн холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцохын зэрэгцээ лавлагаа, мэдээллийн үйлчилгээний нууцлалтай холбоотой мэргэжлийн байгууллагууд, цагдаа, нийгмийн үйлчилгээний бусад байгууллагатай хамтран ажиллахдаа үйлчлүүлэгчийн нууцлалд анхаарал хандуулан ажиллах. Онцгой нөхцөл байдалд мэдээлэл солилцох зохицуулалтын сувгуудыг бий болгож, байнга сайжруулж ажиллах хэрэгтэй.
- *Хүүхэд хамгааллын байгууллагуудтай хамтран хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хянах системийг идэвхтэй ажиллуулах.* Хяналт сайн байснаар тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд туслах, сургуульд дахин хамруулах, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт ажлуудыг үр дүнтэй хийж болно.
- *Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг ханган ажиллах.* Хохирогчдод нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх, боловсролын үйлчилгээнд хамруулах хэрэгтэй. Хүүхэд эргэн нийгэмших боломжийг бүрдүүлэхийн тулд хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллах ёстой. Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүүхдүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг олгох нь зүйтэйг анхаараарай.
- *Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан амьжиргааг дэмжих арга хэмжээг шуурхай зохион байгуулах нь чухал юм.* Хүүхдийн хөдөлмөрийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор гамшигт өртсөн хүүхэд, тэдний эцэг эх, гэр бүлд зориулсан эдийн засгийн тусгай багц хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, хөдөлмөрийн мөлжлөгийн талаар олон нийт, хүүхэд залуучуудад зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах. Ялангуяа хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөх магадлал өндөр эрсдэлт бүлэгт чиглэсэн сурталчилгаа, сургалт зохион байгуулах нь үр дүн өндөр байдаг.

2.3

ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Хүмүүнлэгийн манлайлал. Гамшгийн эрсдэл өндөртэй орон нутагт амьдарч буй малчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг аль болох эрт, цаг алдалгүй авч хэрэгжүүлэх аваас гамшигтай тэмцэх өнөөгийн тогтолцоонд хүүхэд хамгааллыг бэхжүүлэхэд чухал үр дүнтэй. ХИС-гийн хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөр нь Гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд бодит хувь нэмрээ оруулсаар байна. Мэргэжлийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд ХИС-гийн хөгжлийн болон хүмүүнлэгийн хөтөлбөрүүд чухал үүрэг гүйцэтгэсэн. 1999-2017 онд зудаад нэрвэгдсэн малчин өрхийн амьжиргааг дэмжих төсөл, 2011-2016 онд Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, хүүхэд төвтэй бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл, 2016 оноос гамшигт нэрвэгдсэн хүүхдэд сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх төсөл, 2017 онд Монголд анх удаа хүүхдийн сургалтын орчинд Ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа, 2019 онд Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн тойм судалгааны ажлуудыг нэрлэх нь зүйтэй. Гамшиг, хямралд өртсөн эмзэг бүлгийн хүүхэд, гэр бүлд чанартай хүмүүнлэгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх, болзошгүй гамшигт бэлэн байдалд туслах хөтөлбөр, гамшгийн дараа хүүхдэд сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх төслүүд нь хүмүүнлэгийн үеийн хүүхэд хамгаалалд томоохон байр суурь суурийг эзэлж байна.

Шигтгээ 4-т үзүүлсэн жишээ нь манай улсад сүүлийн 20 жилд болсон хамгийн их эдийн засгийн хор хохирол учруулсан байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн малчид, тэдний хүүхдэд нэн шаардлагатай тусламжийг цаг алдалгүй үзүүлсэн нь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын хэрэгжилтэд сайн туршлага юм.



Шигтгээ 4. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал: Хүмүүнлэгийн бодит тусламжэ

“Шороон шуурганд өртсөн хүүхэд, малчин өрхийн амьжиргааг дэмжих” төслөөр Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн 69 малчин өрхөд таван ханатай гэр, 300 малчин өрхөд эрүүл ахуйн багц, 310 малчин өрхөд мөнгөн тусламж үзүүллээ. “Шороон шуурганд өртсөн хүүхэд, малчин өрхийн амьжиргааг дэмжих” төслөөр малчдад өгөх тусламжийг шороон шуурганд гэр нь бүрэн эвдэрсэн, мал болон бусад эд зүйлийн хохирол амссан, хүүхэдтэй, амьжиргааны төвшин доогуур зэрэг байдлыг харгалзан олгосон юм.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын малчин Д.Чимэдцэрэн “Өнгөрсөн гуравдугаар сард манай суманд их хүчтэй шороон шуурга болсон. Шуурганд манайх гэргүй болж, барих ямар ч боломжгүй байсан тул айлын гэр түр гуйж барьж байсан. Манайх шуурганд нийтдээ 100 гаруй толгой малаа алдсан. Гэр өгсөнд маш их баяртай” гэлээ.

Өвөрхангай аймгийн Бүрд сумын малчин З.Хишигдорж “Манайх ам бүл тавуулаа, 2-10 насны гурван хүүхэдтэй. Өнгөрсөн хавар манай суманд хүчтэй шороон шуурга болж, манайх гэргүй болж, малаа хорогдуулсан. Хавар мал идэх өвс, тэжээлгүй болсон байгаа. Шороон шуурганд нийт 150 гаруй бог мал, 20 гаруй үхрээ хорогдуулсан. Шуурганы дараа бэлчээр шороонд даруулж мал идэх өвсгүй болж хорогдсон байгаа. Миний бодлоор бэлчээрийн даац нэмэгдээд, газар чийгшил багатай болсноос хүчтэй шуурга гарч байгаа байх. Гэртэй болсондоо баяртай байна” гэж яриу.

Эх сурвалж: ХИС, 2021 он. “Бидний бүтээсэн амжилтын түүхүүд”

Олон нийтийн чадавхыг бэхжүүлэх. Монгол улсын Гамшгийн эрсдэлийг бууруулах дунд хугацааны стратегийн баримт бичигт гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийг чухалчилсан.



Шигтгээ 5. Нутгийн иргэдэд түшиглэсэн хамтын ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар Азийн Хөгжлийн Банктай 2016-2019 хамтран “Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлсэн.

Гамшгийн эрсдэлийн удирдлагын үндэсний болон орон нутгийн байгууллага, багийн иргэдийн зуд болон ой, хээрийн түймрийн эрсдэлийг удирдах чадавхыг ерөнхий газартай хамтран Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн 12 суманд хэрэгжсэн. Энэ хугацаанд нутгийн иргэдэд түшиглэсэн 139 багийн хөршийн бүлгийг байгуулсан юм. Эдгээр бүлэг нь 1811 өрх, 6918 хүн амтай, 4246 гишүүнтэйгээс 46 хувь нь эмэгтэй гишүүн байна. Үүний 45.3 хувь эмэгтэй ахлагчтай. Бүх “багийн хөршийн бүлэг” хамтран ажиллах гэрээтэй, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Онцгой байдлын газарт бүртгэлтэй.

Нутгийн иргэдийн түшиглэсэн “багийн бүлгийн бүлэг” бүр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулж, сумын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчилжээ. Онцгой байдлын байгууллага, сумын захиргаа, багийн хөршийн бүлгийн гишүүд зуд болон ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжихэд хувь нэмэр оруулсан.

Эх сурвалж: ОБЕГ. 2019 он, Хөгжил дэвшлийн 15 жил

Монгол Улсын Засгийн газраас донор байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн олон нийтэд түшиглэсэн хамтын ажиллагааны сайн жишээг Шигтгээ 5-д харуулсан. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх зэргээр орон нутгийн иргэдийн үүрэг оролцоо нэмэгдэж байгаа нь сайшаалтай төдийгүй энэ нь болзошгүй гамшиг, онцгой байдлын бэлэн байдлыг хангаж, улмаар гамшиг болсон тохиолдолд оролцооны тусламжтайгаар өөрөө өөрийгөө хамгаалах, мэдлэг туршлага олж авдаг.

Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх хамтарсан хөтөлбөр. Нийгмийн хамгааллын өнөөгийн тогтолцоонд тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэх, гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх зорилгын хүрээнд НҮБХС, ХНХЯ, Завхан аймгийн ЗДТГ-тай хамтран гамшгийн эрсдэлийг даван туулахад чиглэсэн нийгмийн хамгааллын туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Зудын гамшигт нэрвэгдсэн сумдын айл өрхүүдэд өвөлжилтийн бэлэн байдлыг хангах, улмаар эрсдэлийг даван туулахад зориулж хүмүүнлэгийн үеийн бэлэн мөнгөнд суурилсан тусламж үзүүлсэн.



Шигтгээ 6. НҮБХС-гийн хамтарсан хөтөлбөр

Малчин айл өрхүүдийг цаг агаарын аюулт үзэгдэл, зудын аюул уршгаас урьдчилан сэрэмжлүүлэх зорилгоор үндэсний болон олон улсын хөгжлийн байгууллагууд хамтран мал сүргийг хамгаалах замаар малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүллээ. Хахир хүйтэн өвлийн улирлыг даван гарахад нь малчдад туслах, хоол хүнс, тэжээлийнх нь аюулгүй байдлыг хангах зорилгоор 5 аймгийн 25 сум, нийслэлийн 1000 гаруй эмзэг бүлгийн малчин өрхөд мөнгөн тусламж үзүүлж тэднийг гамшгаас эрт сэрэмжлүүлэн хамгаалах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн судалгаа явуулж дээрх арга хэмжээний үр нөлөөнд үнэлгээ хийж үзэхэд үр ашиг, зардлын харьцаа 7.1 байсан нь эрт сэрэмжлүүлгийн арга хэмжээ хамгийн үр ашигтай болохыг нотолж байна.

Эх сурвалж: НҮБ-ын СЗАА, 2017-2021 оны НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ

Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарын эрсдэлт хүчин зүйлс ихтэй Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Баянтэс, Тэс сумдын 0-5 хүртэлх насны нийт 2,729 хүүхдийг хамруулсан байна. Энэ төслийн хүрээнд эцэг эхчүүд сэтгэл зүйн бэлтгэлтэй байж, хүүхдэд хэрэгтэй хоол хүнс, өвлийн дулаан хувцас авахад зарцуулсан нь гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын асуудлыг орхигдуулалгүй, харгалзан үзсэн нь сайн туршлага болсон.

ГУРАВ

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА

- 3.1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага
- 3.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт
- 3.3 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

3.1

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

Гамшгийн үед хүүхэд эмзэг өртөмтгий байдаг учраас хүүхдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд хүчтэй хамгаалалтын тогтолцоо шаардлагатай бөгөөд гамшгийн үеийн үйл ажиллагааны төвд хүүхдийн дээд ашиг сонирхлыг анхаарч ажиллахыг чухалчилдаг.








Шигтгээ 7. Монгол Улсын Үндсэн
Хууль, 2-р бүлэг 16.11 зүйл

Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16.11 зүйлд гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.

Шигтгээ 7-т Монгол Улс олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалахаар хуульчилсныг харуулсан. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг нь тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэх зорилготой.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5-р зүйлд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараах таван зарчмыг баримтлахыг заасан.

Зураг 5. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим

-  Хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх
-  Мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх
-  Шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурласан байх
-  Өмчийн хэлбэрийг үл харгалзах
-  Иргэдийн оролцоонд тулгуурлах

Эх сурвалж: УИХ. 2017 он. Гамшгаас хамгаалах тухай хууль.


Зураг 5 нь Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмууд юм. Харин гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд энэ модулийн 1-р сэдвийн үндсэн ойлголт хэсэгт буй “Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандартын 10 зарчмыг¹⁵ баримтална.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага нь i) гамшгийн өмнөх үйл ажиллагаа, ii) гамшгийн үеийн үйл ажиллагаа, iii)

¹⁵ Олон улсын хүний эрхийн стандарт, хүмүүнлэгийн үйл ажиллагааны үеийн хүүхэд хамгааллын Олон улсын эвслээс боловсруулж, үндэсний стандарт MNS 6948:2021-д тусгасан.

гамшгийн дараах үйл ажиллагаа гэсэн гурван үе шаттай хэрэгждэг. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлана. Түүнчлэн МУЗН гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд эрхлэх асуудлынхаа хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах үүрэгтэйгээр оролцдог. Гамшгийн үеийн үйл ажиллагаанд гамшиг, гамшгийн онцгой нөхцөл, аюулт үзэгдэл, ослын үйл ажиллагаа хамаарах ба үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулах ёстой. Гамшгийн дараах үйл ажиллагаанд хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаа орох бөгөөд дотоодын болон гадаад улсын, аж ахуйн нэгж, иргэний хүмүүнлэгийн тусламжийг авч болно.

Зураг 6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага



Эх сурвалж: УИХ, 2017 он. Гамшгаас хамгаалах тухай хууль.

Зураг 6-д Гамшгаас хамгаалах менежментийн бүтэц, үйл ажиллагааны ялгаатай байдлыг дэлгэрэнгүй харуулав. Гамшгаас хамгаалах менежмент нь үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавьдаг.

ОБЕГ нь Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй.

Зураг 7. ОБЕГ-ын үйл ажиллагааны чиглэл



Эх сурвалж: ОБЕГ. <https://nema.gov.mn/aboutus/butets>

Зураг 7-с Гамшгаас хамгаалах хуулийн хүрээнд ОБЕГ нь гамшгийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ. Гамшгийн эрсдэлийн менежментэд Гамшиг үеийн хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, ОУБ-уудыг дэмжлэг үзүүлж ажиллахыг хуульчилдаг.


3.2

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улсын хэмжээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах **Үндэсний зөвлөл**”, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл” байна. Харин гамшгийн онцгой нөхцөл байдлын үед улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах “**Улсын онцгой комисс**”-ыг Засгийн газар, орон нутгийн Онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

Онцгой байдлын байгууллага нь улсын болон орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохицуулна. **Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг** шуурхай байдал, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй *төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, болон холбогдох бусад байгууллагыг* түшиглэн орон тооны бус **Улсын албыг** онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, **Орон нутгийн албыг** тухайн шатны Засаг дарга байгуулна.

Зураг 8. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт



Эх сурвалж: ОБЕГ. <https://nema.gov.mn/aboutus/butets>

Зураг 8-д Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг харуулсан бөгөөд улсын хэмжээнд ОБЕГ гамшгаас хамгаалах чиг үүргийг зохицуулдаг. Гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог Гамшгаас хамгаалах алба гүйцэтгэнэ.

3.3

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг шат шатанд нь төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж хэрэгжүүлнэ (СХЗГ, 2021).

Салбар дундын бүлэг. Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийг ХНХЯ дээр байгуулна. Гишүүд нь БШУЯ, ЭМЯ, ОБЕГ, ЦЕГ, НХЕГ, ХГБЗХГ, ОУБ, болон дотоодын ТББ-ын төлөөллөөс бүрдэнэ (СХЗГ, 2021). Салбар дундын бүлэг нь:

- 1) гамшгийн үеийн хүүхэд хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах,
- 2) хүүхдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- 3) нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх,
- 4) салбар дундын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,
- 5) эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

УОК нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, бодлого шийдвэрт Салбар дундын бүлгээс гаргасан дүгнэлт, саналыг тусгаж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хариуцна.

Зураг 9. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын удирдлага.





Зураг 9-т Монгол Улсын стандарт MNS 6948:2021-аар гамшгийн үеийн хүүхэд хамгааллын удирдлагын бүтцийг харуулсан. Уг стандартын дагуу улсын хэмжээнд гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг хангах үүрэг бүхий Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийг ХНХЯ дээр байгуулахаар заасан (СХЗГ, 2021).

Хүүхэдтэй хамааралгүй салбар гэж байдаггүй. Тиймээс төрөөс хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулахын зэрэгцээ гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг бүрэн нэгтгэхэд нийтлэг стандарт болон салбарын стандартыг хооронд нь уялдуулах шаардлагатай. Тухайлбал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэх чиг үүрэгтэй тусгай зориулалтын мэргэжлийн анги нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүмүүнлэгийн тусламж, гал түймэр унтраах ажиллагаа, хэв журам, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, түр болон хоргодох байрны үйлчилгээ, ус, дулаан, цахилгаан хангамж, санхүү, нөөц, хангалт, хүнс, хөдөө аж ахуй, зам гүүр засвар, инженер техник, цацраг, химийн хяналт, харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа, иргэний бүртгэл, статистик, төмөр зам, нисэх буудлын аюулгүй ажиллагаа зэрэг нийт 21 чиглэлээр ажилладаг (Мэргэжлийн ангийн дүрэм, 2017 он).

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандартад заасны дагуу хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэхдээ дараах арга хэмжээг авна (СХЗГ, 2021). Үүнд:

- Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх,
- Хүүхдийн амь насыг аврах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,
- Осол гэмтэл, хүчирхийлэл, үл хайхрал, мөлжлөгөөс хамгаалах,
- Зохистой хариу арга хэмжээ авах,
- Хүүхдэд ээлтэй орон зай бий болгох зэрэг багтана.

Гамшгийн үед бүх төрлийн хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын бэлэн байдлыг хангах, хүүхдэд учирсан хор уршгийг бууруулах, арилгах, хүүхдийг гамшгийн үеийн кейс менежментийн үйлчилгээнд хамруулах, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэхэд хүүхэд хамгааллын стратегийг уялдуулна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө. Гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгааллын оролцоог тодорхойлсон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Салбар дундын бүлэг боловсруулж, батлуулдаг. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгийн үед хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, кейс менежмент, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг юм. Гамшгийн үеийн Хамгаалах төлөвлөгөөнд хүүхдэд тохиолдож болох эрсдэлийн төрөл тус бүрд ямар байгууллага, ямар үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, хэн нь олон нийттэй харилцах тухай төлөвлөлтийг хийнэ. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд удирдлагын чадавх чухал үүрэгтэй учраас хамгааллын тогтолцооны хүрээнд мэргэжлийн нэгдмэл удирдлага дор хамтарсан багаар ажилладаг.

Алсын хараа 2050, II үе шат (2031-2040) үзэл баримтлал гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого, нөлөөллийн цогц арга хэмжээ, тогтвортой олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмждэг. Онцгой байдлын байгууллага нь НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг 20 гаруй олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаатай ажилладаг. Иймд салбарын олон улсын хамтын ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлаар өргөжүүлэн хамтран ажиллах боломжтой. Тогтвортой хамтын ажиллагааг тогтвортой хүүхэд хамгаалалтай нягт холбогдуулснаар уур амьсгалын өөрчлөлтөөс хүүхдэд гарах сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулахад үр дүнтэй.

Хүүхдэд ээлтэй орон зай. Дэлхийн уурын амьсгалын өөрчлөлтийн улмаас манай улсад гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа нь болзошгүй аюул ойрхон байгааг сануулж байна. ХИС-аас Монгол Улсад анх удаа “**хүүхдэд ээлтэй орон зай**” гэх ойлголтыг танилцуулсан. Хүүхдэд ээлтэй орон зай нь гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын нэн чухал хэрэглэгдэхүүн юм.

Гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгааллын ажилтан бүр хүүхдэд ээлтэй орон зайн ойлголт, мэдлэг, дадлага, чадвартай байснаар хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлдэг.



Шигтгээ 8. Хүүхдэд ээлтэй орон зай

Гамшиг үүссэн нөхцөлд хүүхэд хамгааллын байгууллагын барилга байгууламж эвдэрч нурах, үүнээс үүдэн хэвийн үйл ажиллагаа алдагдан нүүлгэн шилжүүлэх тохиолдол ч гарч болзошгүй юм. Энэ тохиолдолд байгууллага бүр үйл ажиллагаагаа, хаана ч ямар ч нөхцөлд тасалдуулахгүй хэвийн үргэлжлүүлэх үедээ хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох шаардлагатай болдог. Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхдэд ээлтэй орон зай гэдэг нь зөвхөн тоглох газар бус, нийгэм сэтгэл зүй, бие бялдрын асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны (сургалт явуулах, цуглаан уулзалт, арга хэмжээ зохион байгуулах, хүүхэд чөлөөт цагаа өнгөрөөх) газар юм. Хүүхдэд ээлтэй орон зай гэж хүүхэд бие биетэйгээ тоглох, сэтгэл санааг нь сэргээхэд дэмжлэг болох, сурах, амрах аюулгүй тайван байр, байгууламж юм.

Эх сурвалж: ХИС, Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага, хууд. 97-101

ДӨРӨВ

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, КЕЙС МЕНЕЖМЕНТ

- 4.1 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө
- 4.2 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
- 4.3 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент

4.1

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гамшиг, хүмүүнлэгийн үед хүүхэд хамгааллын орчныг сайжруулахад дэлхий нийт анхаарал хандуулж, олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд хүчин чармайлтаа нэмэгдүүлж байна. 2018 оны байдлаар дэлхий даяар 4 хүүхэд тутмын нэг нь гамшиг, зөрчилдөөний бүс нутагт¹⁶ амьдарч байдаг байна. Норвегийн Хүүхэд хамгааллын байгууллагын судалгаагаар дэлхий даяар 2000 оноос хойш зэвсэгт мөргөлдөөнтэй бүс нутагт амьдарч буй хүүхдийн тоо нэмэгдэж байгааг тогтоожээ. 2019 оны байдлаар 1.6 тэрбум хүүхэд (69%) зэвсэгт мөргөлдөөнтэй бүс нутагт амьдарч байна. Өөрөөр хэлбэл, 6 хүүхэд тутмын 1 нь дээрх газар нутагт амьдарч байгаа юм. 2019 онд зэвсэгт мөргөлдөөнтэй бүс нутагт амьдарч буй хүүхдийн тоогоор Африк (179 million) дэлхийд тэргүүлж байсан бол Ойрх Дорнод зэвсэгт мөргөлдөөнтэй бүс нутагт амьдарч хүүхдийн хамгийн (40%) их хувийг эзэлж байна. 0–5 насны 71 сая гаруй хүүхэд амьдралынхаа турш зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэлд амьдарч байна.¹⁷

Гамшиг, онцгой нөхцөл байдалд хэд хэдэн байгууллагууд хамтран хүүхэд хамгааллын кейс менежментийг үзүүлж байгаа тохиолдолд “Гамшгийн үеийн хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө”-ний дагуу ажиллана. Өмнөх сэдэвт дурдсанчлан, Монгол улсын стандарт MNS 6948:2021-д зааснаар ХНХЯ дээр байгуулагдсан, олон салбарын төлөөлөл бүхий Хүүхэд хамгааллын салбар дундын бүлэг нь “Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө”-г боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй. Энэ бэлэн байдлын төлөвлөгөө¹⁸ нь аймаг, дүүрэг, орон нутгаас үл хамааран тодорхой газарзүйн бүсэд буй байгууллагуудыг стандартчилагдсан, нэгдсэн арга зүйгээр хангах замаар Хүүхэд хамгааллын кейс менежмент (ХХКМ)-ийг хэрэгжүүлдэг.

Зураг 10. Бэлэн байдлын төлөвлөгөөний ач холбогдол



16 UNICEF. (January 2021) “UNICEF Humanitarian Action for Children 2018 Overview.” available at: https://www.unicef.org/media/48156/file/UNICEF_Humanitarian_Action_for_Children_2018_Overview_ENG.pdf

17 Østby, Gudrun; Siri Aas Rustad & Andreas Forø Tollefsen. 2020. Children Affected by Armed Conflict, 1990–2019, Conflict Trends, 6. Oslo.

18 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө - Гамшгийн үеийн ХХБТ

Зураг 10-т үзүүлсэн, Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө нь төрийн байгууллага, мэргэжилтний хувьд эрх эдлэгч-хүүхдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, болон тогтолцооны кейс менежментийн тасралтгүй ажиллагааг дэмждэг чухал ач холбогдолтой.

Хүүхэд хамгааллын олон улсын стандарт (Action, 2019)-д хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа, үйл явцыг “Холбогдох, эрх бүхий төрийн байгууллага, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон гамшигт нэрвэгдсэн орон нутгийн төлөөлөл бүгд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг бүрэн, үр дүнтэй, цаг тухайд нь үзүүлэхэд нягт хамтран ажиллах үйл явдал” гэж тодорхойлсон (Action, 2019). Хүүхэд хамгаалал нь бүх хүнд хамаатай хариуцлага юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулиар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах **удирдлагын баримт бичиг** хэмээн тодорхойлсон байдаг. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг Шадар сайд баталдаг (ГХтХ 8.3). Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулахдаа үндэсний стандарт MNS 6948:2021-д нийцүүлэн:

- i) гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах,
- ii) аюулгүй байдлыг хангах,
- iii) бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах,
- iv) эрсдэлээс урьдчилан сэргийлэх,
- v) зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааг тусгахаар зохицуулалт хийсэн байдаг. Төлөвлөгөөнд хавсаргах баримтуудыг Хавсралт 2-оос үзнэ үү.

Дэлхийн Хүүхэд хамгааллын ажлын хэсгийн гишүүн байгууллагууд хүмүүнлэгийн үйл ажиллагаанд мөрдөх “Хүүхэд хамгааллын кейс менежментийн (цаашид ХХКМ гэх) төлөвлөлтийн загвар”-ын боловсруулж, энэ загвартаа үнэлгээ хийх, төлөвлөх, боловсруулах, түгээн дэлгэрүүлэх, чадавхыг бэхжүүлэх, хянан үзэх, мэдээллийг шинэчлэх гэсэн дараах үндсэн 5 алхмыг мөрдөн ажилладаг (CPWG, 2019). Ингэхдээ:

- **Үнэлгээний үе шатанд** хүүхэд хамгааллын кейс менежментийн хэрэгцээ, зорилгыг тодорхойлдог. ХХКМ үйлчилгээнд тохиолдох аюул эрсдэлүүдийг тогтоох, аюулаас учирч болзошгүй хохирол, эдгээрээс хор уршиг учрах магадлал, тухайн эрсдэлийг арилгах эсхүл бууруулахын тулд тогтолцооны болон хувь хүний түвшинд авах хариу арга хэмжээг тодорхойлно.
- **Төлөвлөгөө боловсруулах үе шатанд** оролцогч бүх талууд ХХКМ-ийг боловсруулах/хянах үйл явцын салбар дундын төлөвлөгөөнд идэвхтэй оролцох, ажил мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх нь нэн чухал.
- **Боловсруулах үе шат** нь оролцогч төрийн байгууллагуудын утга учиртай санал зөвлөмж, зөвлөгөө, оролцогч байгууллага доторх хамтын ажиллагаа, зэрэг нь үйл ажиллагааг өөриймсүүлэх мэдрэмжийг бий болгодог. Энэ бол өнөөгийн хэрэгцээ, эмзэг байдлын талаарх мэдлэгийг хуваалцаж тэрхүү хэрэгцээ бүхий хүмүүст хариу арга хэмжээ үзүүлэхэд туслах шилдэг туршлагыг нэгтгэх цаг юм.

- Түгээн дэлгэрүүлэх, чадавхыг бэхжүүлэх үе шат бэлэн байдлын танилцуулга, сургалтын дараа, бүх хүнд ойлгомжтой байдлаар хөрвүүлж Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги болон бусад бүх салбарын төрийн байгууллага, болон салбаруудад системтэйгээр түгээх ёстой.
- Хянан үзэх, мэдээллийг шинэчлэх үе шатанд гамшгийн нөхцөлд Бэлэн байдлын төлөвлөлтийг 6 сар тутамд, эсвэл нөхцөл байдлын гэнэтийн өөрчлөлт эсхүл хүүхэд хамгааллын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай бол аль болох эрх хянах нь чухал. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрсдэл хүчин зүйлс, эмзэг байдал маш хурдан өөрчлөгдөж байдаг. ХХКМ нь одоогийн нөхцөл байдлыг тусгасан тохиолдолд л ашигтай байдаг. Тиймээс ХХКМ-т хамгийн сүүлийн үеийн хэрэгцээ, эмзэг байдлын мэдээллийг тухай бүр оруулна.

Зураг 11. Хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах үндсэн алхам



Зураг 11 нь олон улсын Хүүхэд хамгааллын ажлын хэсгийн гишүүн байгууллагууд хүмүүнлэгийн үед заавал дагаж мөрдөх “Хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлтийн загвар”-ыг үзүүлээ (CPWG, 2019). Аливаа байгууллагын хувьд өөрийн журам, дүрмийг цаг үед нийцүүлэн шинэчилдэг. Үүний адил, салбар дундын үйл ажиллагааны төлөвлөлтийг тухайн гамшиг, онцлог, нөхцөл байдал, цагийн байдлыг тусган тогтмол, тодорхой хугацаанд хянаж, тодотгож байх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах нь бэлэн байдлын асуудал бөгөөд бэлэн байдал нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг бэлэн байдал хэмээн тодорхойлж, хэзээ, хаана, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай зохицуулалтыг тусгасан.

Зураг 12. Хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх 9 алхам



Эх сурвалж: ДЭМБ, Inspire Гарын авлага: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох долоон стратеги, хууд.82-90

Зураг 12-т гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулахдаа нэн түрүүнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үндсэн асуудалд нийцүүлэн ямар дэд системийг авч үзэж, уялдааг холбоог хангах, хэн юуг үндэсний болон орон нутгийн аль түвшинд хийхийг тогтоох гэх мэтээр төлөвлөх боломжтой.

4.2

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийгмийн ажлын мөн чанар нь нийгмийн өөрчлөлт, хөгжил, хүмүүсийн нэгдмэл байдал, хүчирхэгжүүлэлтийг хөхиүлэн дэмждэг. Тиймээс хүүхдийг хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахын тулд иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нь бэлэн байдлын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болдог. Гамшгийн үеийн бэлэн байдлын үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах ажил багтдаг. Эдгээр ажлыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ бөгөөд Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үндэсний стандартаар үндсэн 4 шатлалд ангилсан (СХЗГ, 2021). Гамшгийн үеийн ХХКМ нь нэн түрүүнд гамшигт нэрвэгдсэн, хэрэгцээ шаардлага

бүхий хүүхэд, гэр бүлд төвлөрөх учиртай. Тиймээс Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам (ХНХЯ. 2021)-ын хамгааллын үйлчилгээний шат дараалал, зохион байгуулалтад нийцүүлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн үзүүлэх загварыг 5-р хүснэгтээс харна уу. Энэхүү загвар нь гамшгийн үеийн ХХКМ-ийн хэрэгцээг эрэмбэлж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хүснэгт 5. Гамшгийн үед хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэлт

Үе шат	Үйлчилгээний төрөл	Авах арга хэмжээ
I	Нөхөн сэргээх үйлчилгээ	Дарамт, үл хайхрах байдал, мөлжлөг, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үүсэх урт хугацааны хор хөнөөлийг бууруулах, дахин хор хөнөөл учруулах нөхцөлийг бууруулах
II	Холбон зуучлах үйлчилгээ	Дарамт, үл хайхрах байдал, мөлжлөг, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхдийн эмзэг байдал, аюул заналхийллийн шалтгаан, үүсвэрт анхаарал хандуулах
III	Гэр бүл, олон нийтийн дэмжлэг	Гамшиг онцгой байдлын үед хүүхдийг аюул ослоос авран хамгаалах, гэр бүлээсээ хагацсан, салсан хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, арга хэмжээ авах
IV	Үндсэн үйлчилгээ, аюулгүй байдал	Дарамт, үл хайхрах байдал, мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг бууруулахын тулд хүн амын дундах хүүхэд хамгааллын эрсдэлийн үндсэн шалтгааныг шийдвэрлэх, иргэдийн хандлага өөрчлөх нөлөөллийн ажил хамгийн чухал байдаг. Тухайлбал: хүний нэр төр, эрхийг хүндэтгэн хамгаалах, аюулгүй байдал, нийгмийн үйлчилгээний талаар сурталчилгааны ажил хийх.

Хамгийн их анхаарал хандуулах ёстой асуудал нь “Гамшиг бэлэн байдлын төлөвлөгөө”-г гаргасны дараа **байнгын дадлага, сургуулилт хийлгэх** нь урьдчилан сэргийлэлтийн амин сүнс буюу үндсэн арга хэмжээ юм.

Зураг 13. Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцын урсгал



Эх сурвалж: WHO, 2016. A strategic framework for emergency preparedness

Зураг 13-т гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь дахин давтагдах тойрог урсгалаар явагддагийг харуулсан. Үүнд: эхлээд төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад тухайн төлөвлөгөөнд хяналт үнэлгээ хийж, алдааг залруулах, төлөвлөгөөнд эрсдэлд хүргэх хүчин зүйл байгаа эсэхийг илрүүлэх, арилгах, хэрэгжилтийн чадавхыг үнэлэх гэсэн 4 үе шатыг байнга давтамжтайгаар хийдэг. Үүний үр дүнд бэлэн байдлын төлөвлөгөө туршигдаж, амьдралд ойр болохын зэрэгцээ, нөхцөл байдалд уялдаа холбоотойгоор саадгүй хэрэгжих учиртай.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.2-д заасанчлан орон нутгийн онцлогт тохирсон, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулахаар заасан. Энэхүү алба, мэргэжлийн алба, сайн дурын ажлын хэсгийг гамшгийн үед хүлээсэн үүрэг даалгаврыг зөв, зохистой биелүүлэх дадал суулгах, үр чадварыг эзэмшүүлэхийн тулд байнгын дадлага, сургуулилт хийлгэх нь чухал юм. Ингэснээр Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кэйс менежментийн төлөвлөгөөг төлөвлөлтийн дагуу үр дүнтэй, амьдралд бодитоор хэрэгжүүлж чадна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.2-д зааснаар “нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох” нь Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кэйс менежментийг үр дүнтэй байлгаж чадна.

Үндэсний стандарт MNS 6948:2021-д Гамшгийн үеийн Хүүхэд хамгааллын кэйс менежмент (ХХКМ)-д дараах ажлуудыг зайлшгүй хийх ёстой.

- Хүүхдийг кэйс менежментийн үйлчилгээнд хамруулах нөхцөл, эрэмбэлэх шалгуурыг боловсруулах;
- Шийдвэр гаргах явцад хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзэх үнэлгээний аргачлалыг боловсруулж ашиглах;
- Хүүхдийг нийгмийн үйлчилгээнд аюулгүй, ёс зүйтэй холбон зуучилж, үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээллийн санг тогтмол шинэчилж байх;
- Эрсдэлтэй хүүхдийг ёс зүйтэй, аюулгүй илрүүлэн тодорхойлж, нийгмийн үйлчилгээнд холбон зуучлахад бусад салбартай хамтран ажиллах;
- Салбар дундын мэдээлэл хуваалцах журам боловсруулж мөрдөх.

Дээрх ажлууд нь Бэлэн байдлын төлөвлөгөөний 5 дахь үе шат буюу хянах, мэдээллийг шинэчлэх үйл ажиллагаатай холбогдоно. Гамшгийн үеийн ХХКМ-ийг хэрэгжүүлэхдээ Үндэсний хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн боловсруулж баталсан Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын удирдамж, буюу бэлэн байдлын төлөвлөгөө, одоо байгаа мэдээллийн санг ашиглахыг санал болгодог (СХЗГ, 2021). Үндэсний хүүхэд хамгааллын мэргэжлийн анги мэдээллийг аймаг, нийслэл, дүүргээр төрөлжүүлэн гаргах ба гамшгийн эрсдэлийн мэдээлэлд үндэслэн төлөвлөлтөө тухай бүр шинэчилнэ. Гамшгийн эрсдэлийн мэдээллийн төрөл:

- Тухайн онцгой байдлын гамшигт өртсөн,
- Нас барсан,
- Сураггүй болсон,
- Гэмтсэн,
- Эцэг эхээсээ төөрч салсан,
- Хоол хүнсний хомсдолд орсон,
- Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан тухай мэдээллүүд багтана.

4.3

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН КЕЙС МЕНЕЖМЕНТ


Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент нь гамшигт өртсөн орон нутагт байгаа эрсдэл өндөртэй хүүхдэд чиглэдэг. Ингэхдээ тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний гадна хоцорсон хүүхдийг илрүүлэн, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ. Хүүхэд хамгааллын “гамшгийн кейс менежмент”-ийн онцлог нь тогтолцооны түвшний кейс менежмент болон тохиолдлын кейс менежментийг гамшгийн нөхцөл байдлын улмаас “нэг мөчлөг”-т зэрэгцэн хэрэгжүүлэхийг шаарддаг.

Хүүхэд хамгааллын гамшгийн кейс менежмент нь өргөн хүрээнд олон талын байгууллагын оролцоог шаардахын хамт одоо байгаа хүүхэд хамгааллын тогтолцоо дээр суурилдаг. Хэрэв одоогийн тогтолцоонд сул, хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх юм бол тэр хэмжээгээр гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд сөргөөр нөлөөлнө. Тиймээс гамшгийн үеийн хүүхэд хамгааллын менежмент нь төрөөс иргэддээ үзүүлж буй үйлчилгээг тасралтгүй сайжруулахыг шаарддаг.

Хүүхэд хамгааллын олон улсын эвслээс гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежментийг «Хүүхэд, болон түүний гэр бүлийн хэрэгцээ шаардлагыг шууд дэмжлэг болон холбон зуучлах үйлчилгээгээр дамжуулан, зохистой, системтэй, цаг тухайд нь, тухайн төсөл хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх арга зам» хэмээн тодорхойлжээ (CPiE, 2017). Гамшиг хамгийн эмзэг нөхцөлд буй хүүхдэд зөв цагт нь, хамгийн оновчтой цогц үйлчилгээг уялдаа холбоотой, хамгийн шинэлэг, хамгийн ойлгомжтой, хамгийн сайн зохицуулалтайгаар хүргэх үйл ажиллагаа юм.

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент нь хүүхдийн эрх, хүүхдийн хөгжил болон хүүхэд хамгааллын үндсэн мэдлэг ойлголтыг шаарддаг. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежментийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн салбар дундын асуудлуудын харилцан нөлөөлөл, уялдаа харилцаа, ил тод, хариуцлагатай, мэргэжлийн нэгдмэл удирдлагатай, олон талт оролцоог хангасан байхыг шаарддаг.

Зураг 14. Салбар дундын асуудлууд



Зураг 14-т үзүүлсэн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын бүхий л үйлчилгээг авч үзэх ёстой. ОУ-ын хүмүүнлэгийн үйл ажиллагааны үеийн хүүхэд хамгааллын стандартад (Action, 2019) дээрх салбар дундын суурь асуудлуудыг тусган оруулсан. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлс, мөн даван туулах чадварыг харгалзан үздэг.

Гамшиг болон түүний хүүхдэд учруулж буй эрсдэлүүд нь нийгмийн бүх түвшинд, төрөл бүрийн бэрхшээл дагуулж байдаг олон талт асуудал учраас хувь хүн, гэр бүл, орон нутаг, үндэсний түвшинд нэгэн зэрэг шийдвэрлэхэд гамшгийн үеийн ХХКМ тусална. Үүний тулд нийгмийн тогтолцооны бүх түвшинд хамгаалах хүчин зүйлс болон эрсдэлт хүчин зүйлсийг зэрэг анхаарах шаардлагатай (Батхишиг, А., 2019). Нийгэм-экологийн загварыг гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент түгээмэл ашигладаг.

Зураг 15-д тохиолдлын кейс менежмент ба гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент нь нэг зэрэг, хэд хэдэн түвшинд зэрэгцэн хэрэгжинэ. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын кейс менежмент нь тогтолцооны түвшний кейс менежмент гэж ойлгож болно.

Зураг 15. Тохиолдлын кейс менежмент ба гамшгийн үеийн кейс менежмент



Тогтолцооны кейс менежментийг ажиллах үйл явцыг тайлбарлая: Гамшгийн аюул нь гамшгийн төрөл, орон нутагт учруулсан хохирлын хэмжээ, үзүүлсэн сөрөг нөлөөл зэрэг нь хүүхдийн эрсдэлт өртөмтгий, эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг тул хүүхэд хамгааллын шат шатны мэргэжлийн анги хүүхдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.


Хэрэв орон нутагт ажиллаж байгаа хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид зарим хэрэгцээт үйлчилгээ үзүүлэх нөөц байхгүй тохиолдолд Бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгаснаар бүсийн хамтран ажилладаг байгууллагуудтай зааврын дагуу мэдээлэл солилцон хүүхдэд холбон зуучлалаар дамжуулан бусад шаардлагатай үйлчилгээнд шуурхай хамруулах уян хатан боломжийг хангана.

Сайн кейс менежмент нь гэр бүлийн хэрэгцээ, нөхцөл байдлыг бүхэлд нь анхааран үзэх, хувь хүүхдийг хэрхэн хамгаалах талаар шийдвэр гаргахаасаа өмнө гэр бүлийн гишүүдтэй зөвшилцөхийг кейс ажилтнаас шаарддаг. ХХХТХ-ийн хувьд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчийнхаа асрамж, хамгааллыг хүртэх боломжгүй болсноос тэдний эрхийг хамгаалах үүргийг Төр өөртөө авсан нөхцөлд, кейс менежментийн үйл явцын нэн тэргүүний шаардлага нь “гэр бүлийг нь олж, эргэн нэгтгэх” явдал юм.

Байгалийн гамшиг нүүрлэх, иргэний дайн болсноос эсвэл хүүхдээ хаях, албаар тусгаарлагдах зэрэг маш олон шалтгаанаар хүүхдүүд асран хамгаалах хүнгүй болж, хүүхэд гэр бүлээсээ тусгаарлагддаг. Асран хамгаалах хүнгүй болон тусгаарлагдсан хүүхдүүд нь шилжиж суурьшиж буй хүүхдүүд дундах хамгийн том хийгээд анхаарал тавих ёстой чухал бүлэг юм. Харгалзах хүнгүй охид, хөвгүүд хүйсээс хамааран, ялгаа бүхий эрсдэлтэй учирдгийг кейс ажилтан анхаарч, үүнийг хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, кейс менежментийн хариу үйлчилгээнд харгалзан үзэх ёстой. Үүний жишээ болгож гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдийн гэр бүлийг олж эргэн нэгтгэх кейс менежментийн жишээг доор үзүүлсэн Зураг 16-д харуулав.¹⁹

¹⁹ ХИС, Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй

Зураг 16. Гэр бүлээсээ хагацаж, тусгаарлагдсан хүүхдийн гэр бүлийг олж эргэн нэгтгэх үе шатууд



Эх сурвалж: ХИС, 2020, Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй

Салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах нь гамшгийн үеийн ХХКМ-д нэн чухал. Гамшгийн үеийн ХХКМ-ийг хэрэгжүүлснээр одоогийн хүүхэд хамгааллын тогтолцооны салбар дундын хамтын ажиллагааг илүү бэхжүүлэхийн зэрэгцээ төрийн үйлчилгээний чадамжийг нэмэгдүүлдэг. ДЭМБ “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх INSPIRE шалгуур үзүүлэлтийн удирдамж болон үр дүнгийн хүрээ”-г боловсруулсан (ДЭМБ, 2018) бөгөөд энэ арга зүй нь өөрчлөлтийн онолд суурилсан. Улсын болон орон нутгийн хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний үр дүн, өөрчлөлтийг хянаж, үнэлэх боломжийг бүх түвшинд олгож байдаг байна.

Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх - оролцогчдын хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархалт, хор уршгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хэрэгцээг үнэлэх - хэрэгжиж байгаа хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйлчилгээ, үйл ажиллагаа, дэд бүтэц гээд асуудалтай холбоотой бүх нөхцөл байдлыг үнэлнэ.

Интервенцийг сонгох - интервенцийг улсын болон орон нутгийн чадавх, нөөц бололцоонд нийцүүлэн сонгохдоо үндсэн шинж чанарыг алдагдуулахгүй байх ёстой. Энэ хүрээнд зарим нэг өөрчлөлтийг оруулахдаа хүлээн зөвшөөрч болох, хүлээн зөвшөөрч болохгүй дараах зүйлсийг анхаарна.

Хүснэгт 6. Интервенцийг нийцүүлэхэд анхаарах зүйлс INSPIRE 7

Хүлээн зөвшөөрч болох өөрчлөлт	Хүлээн зөвшөөрч болохгүй өөрчлөлт
Арга зүйн материалыг орчуулах, үгийг өөрчлөн сонгох	Оролцогчдын хөтөлбөрт оролцох хугацааг багасгах, хичээлийн цагийг танах.
Хүүхэд, насанд хүрэгчдийн зураг дүрсийг зорилтот бүлгүүдэд нийцүүлэн төсөөтэй зураг дүрсээр солих	Сурах ёстой гол мэдээлэл, чадварыг хасах.
Соёлын онцлогтой мэдээллийг орон нутгийн онцлогтой мэдээллээр солих	Сэдвүүдийг хасах.
Зарим дасгал, үйл ажиллагааг хүний биед хүрэх орон нутгийн хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх	Онолын үндэслэлийг өөрчлөх
Оролцогчдын анхаарлыг татах, илүү өөрсдөд нь хамаатай болгохын тулд орон нутгийн нотолгоонд суурилсан агуулга нэмэх.	Сайн бэлтгэгдээгүй сургагч, сайн дурын ажилтнаар сургалтыг хийлгэх.
	Ажилтнуудын оролцоог багасгаж тоог цөөлөх.

Эх сурвалж: ДЭМБ, INSPIRE арга зүйн тойм: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 7 стратеги, хууд.85-86

Улсын болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэх - Улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд i) үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөөц, тоног төхөөрөмж, дэд бүтцийг бэхжүүлэх, ii) Хүний нөөцийг бэхжүүлэх, iii) харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, iv) үйл ажиллагааны хэрэгжилтийг зорилт, үр дүнгээр үнэлэх.

Төсвийг тооцоолох - үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд нийт шаардлагатай төсвийг тооцоолно. Үндсэн болон урсгал зардалд дүн шинжилгээ хийснээр төсвийн хуваарилалтыг оновчтой хийхэд тусална.

Санхүүжүүлэх эх үүсвэрээ тодорхойлох - Манай улс Хүүхэд хамгааллын тухай хуулиар²⁰ хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэхээр заасан. ГХТХ-ийн хүрээнд²¹ улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, орон нутгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

Хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, удирдах - гамшгийн үеийн ХХКМ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд удирдлагын манлайлал, зохион байгуулалт, чадвартай мэргэжилтнүүд хамгийн чухал. Орон

20 УИХ (2016) Хүүхэд хамгааллын тухай хууль. Хүүхдэд хамгааллын санхүүжилт 23-р зүйл

21 УИХ (2017). Гамшгаас хамгаалах тухай хууль. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт. 10-р бүлэг.

нутгийн хэрэгцээ, нөөцөөс гадна төрийн удирдах дээд болон дунд шатны байгууллагын удирдлагуудын мэргэжлийн үр чадвар, туршлага, харилцааны үр чадвар болон анхан шатны нэгжийн ажилтнууд дараах үр чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- Салбар дундын зохицуулалт, хэрэгжилт
- Хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах, удирдан зохицуулах, хяналт тавих
- Мэдээлэл цуглуулах, үнэлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлэх
- Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх
- Хариуцлагын тогтолцоо
- Бодлого болон эрх зүйн орчны асуудлууд багтана.

Хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ - Хяналт шинжилгээ мэдээллийг цуглуулах, дүгнэх, тасралтгүй үйл явц юм. Хяналт-шинжилгээ нь үр дүнтэй холбоотой үзүүлэлтийг хэмждэг бол үнэлгээ нь үр дүнгийн урт хугацааны үр ашиг, нөлөөг хэмжинэ. Хяналт шинжилгээ, үнэлгээг оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэглэснээр үр дүн сайжирна. Салбар дундын зохицуулалтын эрх зүйн орчин, үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх нэмэлт мэдээллийг 5-р модулиас дэлгэрүүлж үзнэ үү.

ХХКМ-ийг дүнтэй хэрэгжүүлэх нь оролцогч салбаруудын бэлэн байдлаас шууд шалтгаална. ХХКМ-ийн хэрэгжүүлэхэд салбарын чадавх болон уялдаа холбооны зохицуулалт сайн байснаар гамшигт нэрвэгдсэн газар нутагт буй өндөр эрсдэлтэй хүүхэд, гэр бүлийн аюулгүй байдал хангагдаж, эмзэг байдлыг бууруулна. Гамшгийн үеийн ХХКМ-ийн үр дүн **хүртээмжтэй** байна. Аймаг, дүүргийн түвшний уялдаа холбооны механизмыг үндэсний түвшний ерөнхий уялдаа холбооны механизмтай хэрхэн холбох талаар төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Салбар дундын уялдааг хангах аргачлалыг энгийнээр томьёолж загварчилж болохоор байна.

Зураг 17. Гамшгийн үеийн ХХКМ-ийн аргачлалын томьёолол



Зураг. 17-д НҮБХС-ын INSPIRE шалгуур үзүүлэлтийн удирдамж болон үр дүнгийн хүрээг эх сурвалж болгон ашиглав (НҮБХС, 2018). Салбарын онцлог, ХХКМ-д оруулах хүчин чармайлт, уялдаа холбооны механизмыг саадгүй ажиллуулах боломж нь бэлэн байдлын үр дүнг нэмэгдүүлнэ.

Оролцогч талууд бүх түвшинд гамшгийн үед ХХКМ хэрэгжүүлэх кейс менежментийн хүрэлцээ, хүртээмжтэй, хүүхэд-төвтэй, тасралтгүй байдлыг хангаж ажиллана. Монгол Улсын MNS 6948:2021 стандартаар гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдэд үзүүлэх тохиолдлын кейс менежментийг i) үйлчилгээ шаардлагатай хүүхдийг илрүүлж, шалгуурын дагуу бүртгэх; ii) хүүхэд, гэр бүлийн хэрэгцээ, давуу талыг үнэлэх; iii) хүүхдийн хэрэгцээнд нийцсэн кейс менежментийн төлөвлөгөө боловсруулах; iv) цаг хугацаатай, хэмжигдэхүйц зорилт, үйл ажиллагааг төлөвлөх; v) төлөвлөгөөг хэрэгжүүлэх; vi) шууд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ холбон зуучлах; vii) үр дүнг хянах; viii) кейсийг хаах үе гэсэн шатаар үзүүлнэ.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүүхдэд яаралтай анхны тусламж үзүүлэх

Иргэн бүр хүүхдэд яаралтай анхны тусламжийг зөв, оновчтой техник, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлж²² сурах үүрэгтэй. Үүний тулд юуны өмнө үндсэн 4 зарчмыг баримтална.

Орчныг ажиглах	Осол болсон газрын орчныг ажиглаж чухам ямар аюул осол тохиолдсоныг тогтоох Ослын газрыг судлахдаа, эргэн тойрноо сайтар ажиглаж таны болон бусад хүмүүсийн амь насанд аюул учруулах ямар нэгэн зүйл байгаа эсэхийг сайтар нягтална. Хэрвээ таны амь насанд аюул учрахаар бол зохих газарт нь мэдэгдэж хүлээх хэрэгтэй. Харин Танд ямар нэгэн аюулгүй тохиолдолд тусламж үзүүлж болно.	<ul style="list-style-type: none"> - Чухам ямар осол болоо вэ - Энэ осол хэр зэрэг аюултай вэ? - Хэчнээн хүн осолд өртөөд байна вэ? - Ослын газрын эргэн тойронд байгаа хүмүүсээс Танд туслах хүн байна уу? гэх асуултуудад хамгийн түрүүнд хариулт олох хэрэгтэй.
Эхний үзлэг хийх	Эхний үзлэгийг хийхдээ эхлээд гэмтсэн хүн ухаантай байгаа эсэхийг хамгийн түрүүнд тогтооно. Ингэхдээ асуулт асуух, татаж үзэх, зөөлөн цохих зэрэг ямар нэгэн аргаар мэдэж болно. Ямар ч тохиолдолд хэсэг хугацаанд ажиглах нь зүйтэй.	<ul style="list-style-type: none"> - Ухаантай байгаа эсэх - Амьсгалын зам чөлөөтэй эсэх - Өөрөө амьсгалж чадаж байна уу? - Судасны лугшилт аль судсанд байна - Цус алдаж байгаа эсэхийг нягтлан шалгана.
Эмнэлгийн тусламж дуудах	Эмнэлгийн тусламж дуудах 103, 105	Анхны тусламжийн үндсэн зарчмуудын цөм хэсэг нь аль болох түргэн эмнэлгийн тусламж дуудах явдал юм. Осол болсон газрын тухай болон осолд өртөгчийн биеийн байдлын талаар таны өгч байгаа мэдээлэл нь үнэн зөв, дэлгэрэнгүй, шуурхай, тодорхой байвал эмнэлгийн ажилтнуудад шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах бололцоог олгодог.
Хоёр дахь үзлэг хийх	Хоёрдох үзлэгийг хийж өөр ямар нэгэн гэмтэл байгаа эсэхийг шалган тусламж үзүүлнэ. Хэрэв өвчтөн ямар нэг ойлгомжгүйгээр муудаж эхэлбэл та анхан шатны үзлэг шинжилгээг давтах ёстой.	<ol style="list-style-type: none"> 1. Гэмтсэн хүнд өөр ямар нэгэн зовуурь байгаа эсэхийг асуух 2. Амьсгалын хэмнэл, судасны цохилт, арьсны өнгө, биеийн дулааныг шалгах 3. Бүх биеийн үзлэг, толгой, хүзүү, цээж, хэвлийн эцэст тулгуур хөдөлгөөний эрхтнийг үзнэ. 3. Хоёрдох үзлэгийг дээрх дэс дарааллаар эмнэлгийн тусламж иртэл 5 минут тутам хийж илрүүлсэн мэдээллээ бичиж тэмдэглэх хэрэгтэй.

Эх сурвалж: ГССҮТ, 2007 он. Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж, 2 дахь хэвлэлт. УБ.

²² ГССҮТ, 2007 он. Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж, 2 дахь хэвлэлт. УБ.

Яаралтай анхны тусламж үзүүлэх үеийн **DRAB** зарчим

Зарчим	Зорилго	Дэс дараалал
D-danger	Аюулыг шалгана. Тухайн осол танд болон бусдад, мөн гэмтсэн хүний амь насанд хэр аюултай байна вэ гэдгийг тогтоох	1. Гэмтэл учруулж байгаа аюул үргэлжилж байгаа эсэхийг шалгана. Жишээлбэл: гал түймэр, угаарын хий, цахилгаан гүйдэл гэх мэт 2. Хэрвээ боломжтой бол гэмтсэн хүнээ аюулаас холдуулах эсвэл аюулыг зайлуулна.
R-response	Ухаантай эсэхийг шалгах.	А. Насанд хүрсэн хүн болон ярих чадвартай хүүхэд байвал: 1. Нэрийг нь асуух 2. Мөрөн дээрээс нь зөөлөн татах Б. Хэрэв 1 хүртэлх настай хүүхэд байвал: Зөөлөн ярьж, дуудаж сэрээж болно. АНХААР! 1 хүртэлх насны хүүхдийг мөрөн дээрээс нь татах буюу хөдөлгөж болохгүй.
A-Airway	Амьсгалын замыг шалгаж, чөлөөлөх	Амьсгалыг хэрхэн шалгах вэ? 1. Цээжний төвөлзөх хөдөлгөөнийг ажиглана. 2. Чихээ цээжинд нь наан чагнана. 3. Хамрын үзүүрт хөвөн утас, үс барьж болно. 4. Нүдний шилийг хамарт нь ойртуулан барьж үзэж болно. 5. Гараа цээжин дээр нь тавьж тэмтрэх гэх мэт аргуудаар амьсгалж байгаа эсэхийг шалгаж болно.
B-Breathing	Амьсгалын замыг чөлөөлж амьсгалуулах	Гэмтсэн хүний амьсгалыг 10 секунд орчим шалгасны дараа амьсгалын замд байгаа саадыг арилгах арга хэмжээг авна. 1. Амыг нь ангайлган аман доторх зүйлийг хуруугаараа ухаж гаргана. 2. Толгойг хажуугаар нь зөөлөн гэдийлгэнэ. 3. Анхны тусламж үзүүлэгч нь 1 гараа шилэн хүзүүн доогуур оруулж бага зэрэг өндөрлөөд нөгөө гараараа духнаас нь барьж гэдийлгэнэ. 4. Эрүүг доош татаж амыг ангайлгана. Амьсгалын замыг чөлөөлсний дараа амьсгалахгүй хэвээр байвал доор өгүүлсэнчлэн зохиомол амьсгалыг хийнэ

Судасны цохилтыг үзэх:

Насанд хүрсэн хүн болон 9-өөс дээш насны хүүхдэд:

- Гүрээний эсвэл шууны судас дээр долоовор болон дунд хуруугаар зөөлөн тэмтэрнэ.
- 1 хүртэлх насны хүүхдэд: Бугалгын дотор талд долоовор, дунд хурууг байрлуулж зөөлөн тэмтэрнэ.

АНХААР! Судасны цохилтыг эрхий хуруугаар хэзээ ч тэмтэрч үздэггүй. Учир нь эрхий хурууны өөрийнх нь судасны цохилт мэдэгддэг, мөн арьс нь зузаан учир муу мэдэрдэг.

Даралттай иллэг буюу CPR гэдэг нь: Cardio - зүрх Pulmonary - уушги Resuscitation - сэхээн амьдруулалт гэсэн утгатай бөгөөд дэлхийн аль ч улс орнуудад CPR гэж товчлон нэрлэдэг. CPR-ийг томьёолбол: зохиомол амьсгал / зүрхний даралт = 2/15 гэсэн харьцаатай байна.

АНХААР! CPR нь хэдэн насны хүүхдэд хийхээс шалтгаалан дараах байдлаар ялгаатай хийнэ.

А. 1-8 настай хүүхдэд:	<ol style="list-style-type: none"> 1. Нэг удаа амьсгал өгнө. 2. Судасны лугшилтыг үзнэ. 3. Өвчүүний голд 1 гарын алгыг байрлуулна. 4. Таван удаа зүрхний даралттай иллэг хийнэ. <p>Өөрөөр хэлбэл: Зохиомол амьсгал/ зүрхний даралт = 1/5 гэсэн харьцаатай байна.</p>
Б. 1 нас хүртэлх хүүхдэд:	<ol style="list-style-type: none"> 1. Нэг удаа амьсгал өгнө. Дараагийн ээлжид удаа өгнө. 2. Судасны лугшилтыг үзнэ. 3. Өвчүүний голд долоовор, дунд хуруугаараа дарна. 4. Даралтыг 5 удаа хийнэ. Өөрөөр хэлбэл: Зохиомол амьсгал / зүрхний даралт = 1/5 2/5 <p>Хэрэв судас цохилж байвал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дөрвөн секундэд 1 удаа зохиомол амьсгал өгнө. 2. Амьсгал, судасны лугшилтыг минут тутамд шалгана.
В. 0-1 настай хүүхдэд:	<ol style="list-style-type: none"> 1. Хүүхдийг дээш нь харуулж хэвтүүлнэ. 2. Тусламж үзүүлэгч гэмтсэн хүүхдийн ам, хамарт нь зэрэг амьсгал өгнө. Зохиомол амьсгалыг 3 секунд тутамд 1 удаа зөөлөн өгнө. 3. Амьсгал, судасны лугшилтыг минут тутамд шалгана.

CPR-буюу зүрх уушгины сэхээн амьдруулалтыг 2 хүн зэрэг хийж болно. Эхний хүн зохиомол амьсгал өгч судасны цохилтоо үзэх, нөгөө хүн зүрхний даралтат иллэг хийх буюу үүнийг хийж байгаа хүн чанга тоолох хэрэгтэй.

Хавсралт 2. Бэлэн байдлын төлөвлөгөөнд хавсаргах баримтууд

№	Баримтууд	Тийм	Үгүй
1	Одоогийн кейс менежментийн талаарх тэмдэглэл		
2	Агуулга		
3	Зорилго, хамрах хүрээ		
4	Хүртээх, хянах, тодотгол хийх		
5	Нэр томъёоны тодорхойлолт		
6	Үндсэн зарчим		
7	Түншүүдийн үүрэг хариуцлага, үүнд гэрээ/зохицуулалт		
8	Хүүхэд хамгааллын кейс менежментийн шалгуур, бүдүүвч зураглал		
9	Хүүхэд хамгааллын кейс менежментэд хамруулах боломжтой тохиолдлын чиглүүлэг, матриц		
10	Шуурхай хариу арга хэмжээ авах кэйсийн журам, лавлагааны маягт		
11	Кейс файл: үүнд таниулсан зөвшөөрөл, илрүүлэх/бүртгэх, үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, ахицыг хянах, хаах/		
12	Салбар дундын үйлчилгээний төлөвлөлт болон үйл ажиллагааны зураглал		
13	Кейс ажилтан, кейс менежментийн шууд удирдлагын үүрэг, хариуцлага		
14	Боловсон хүчний харьцаа ба санал болгож буй орон тооны бүтэц		
15	Кейс менежмент суурь чадавх		
16	Чадавх бэхжүүлэх үнэлгээ, төлөвлөгөө		
17	Баталгаажуулсан албан тушаалтнуудын гарын үсэг, батлагдсан он сар, өдөр		
18	Хавсралтууд: Кейс менежментийн маягт, Мэдээлэл хамгаалах нөлөөллийн үнэлгээний хуудас, Мэдээлэл хамгаалах протокол, Мэдээлэл солилцох протокол, Хяналт үнэлгээний хэрэгсэл, Ажлын байрны тодорхойлолт, тусгай кейсийн удирдамж (жишээ нь хараа хяналтгүй хүүхдүүд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн гэрлэлт, бие махбодын хүчирхийлэл, зэвсэгт бүлэглэлд элссэн хүүхэд гэх мэт)		

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

- Батхишиг, А. (2019). Нийгмийн ажил: Хамгаалах хүчин зүйлс. УБ: Сэлэнгэ Пресс, ХХК.
- БОАЖЯ. (2020). Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт. УБ.
- БШУЯ & НҮБХС. (2019). Монгол улс боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл тайлан. УБ.
- ХНХЯ. (2022): Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар. Retrieved from ХНХЯ-ны цахим хуудас: <https://mlsp.gov.mn/content/detail/2257>
- Дэлхийн зөн Монгол, Азийн сан. (2021). Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. УБ.
- ДЭМБ. (2016). Inspire Гарын авлага: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох долоон стратеги. УБ.
- Монгол Улсын Засгийн газар. (2017). Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208210&showType=1>
- Монгол Улсын Засгийн газар. (2019). Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолын хавсралт Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон зорилт.
- ОБЕГ. (2019). Онцгой байдлын байгууллагын 15 жилийн ойд зориулсан эмхэтгэл: Хөгжил дэвшлийн 15 жил. УБ.
- Сфер Холбоо. (2018). Сфер гарын авлага, Хүмүүнлэгийн тунхаг ба хүмүүнлэгийн хариу арга хэмжээн дэх стандарт, 4 дэх хэвлэл.
- СХЗГ. (2021). Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага. MNS 6948:2021.
- УИХ. (2016). Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/11710>
- УИХ. (2017). Гамшгаас хамгаалах тухай хууль. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12458>
- УИХ. (2020). Алсын хараа 2050. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>
- ҮСХ. (2021). Хүн ам орон сууцны тооллого: Хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц. Улаанбаатар

- ХИС. (2007). Онцгой байдал дахь хүүхэд хамгаалал, тэргүүлэх чиглэл, зарчим, практик. УБ.
- ХИС. (2017). Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага. УБ.
- ХИС. (2021). Бидний бүтээсэн амжилтын түүхүүд 2021. УБ.
- ХНХЯ. (2021). Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389973164651&showType=1>
- ХЭҮК, НҮБХХ. (2020). Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ гарын авлага. УБ.
- Чанцалсүрэн, М. & Батхишиг, А. (2022). Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тархалтын харьцуулсан судалгаа. Нийгмийн ажил сэтгүүл 05/2022-13. УБ: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Чанцалсүрэн, М. & Цогбаяр, Б. (2020). Түргэвчилсэн үнэлгээний тайлан. Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ ЖСХ, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хамгаалал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд үзүүлж буй нөлөөллийн судалгаа. УБ.
Retrieved from: <https://genderhub.mn/contents?category=2>
- Чанцалсүрэн, М. (2021). Монгол Улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа. УБ
- ЭМЯ. (2022). Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар.
Retrieved from: ЭМЯ-ны цахим хуудас: <https://moh.gov.mn/uploads/files/4eda93e40326054d507c4c4f291dfb53ddb1390.pdf>

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Bosher, Lee, Ksenia Chmutina, and Dewald van Niekerk. 2021. "Stop Going Around
- CHS Alliance, Groupe URD, Sphere. (2022). Core Humanitarian Standard on Quality and Accountability. Retrieved from: <https://corehumanitarianstandard.org/the-standard/language-versions>
- Davies, G. and Spencer, A. (2022) 'Complementary approaches between international and local protection advocacy: "Don't speak for me, I'll speak for myself"'. HPG briefing note. London: Retrieved from: chrome-extension://efaidnbnmnibpcjpcglclefindmkaj/https://www.globalprotectioncluster.org/sites/default/files/2022-05/advocacy_ip_national-international_collaboration_web_mhvpzyk.pdf
- Bosher, L. Chmutina, K. and Niekerk, D. (2021). Stop going around in circles: Towards a Reconceptualisation of Disaster Risk Management Phases". Loughborough University. Retrieved from: https://www.researchgate.net/publication/351704277_Stop_going_around_in_circles_towards_a_reconceptualisation_of_disaster_risk_management_phases
- IRC& UNHCR (2021). Your guide to protection case management.
- The Alliance for Child Protection in Humanitarian Action. (2019). Minimum standards for child protection in Humanitarian action. Retrieved from: <https://resourcecentre.savethechildren.net/document/minimum-standards-child-protection-humanitarian-action-2019-4th-edition>

- UN Conference on trade and development UNCTAD, (2021). Handbook of statistics 2021. Geneva
- UNFAO. (2018). From Early Warning to Early Action in Mongolia - Bracing for the cold to protect livestock and livelihoods. Retrieved from: <https://www.fao.org/publications/card/en/c/CA1210EN>
- UNICEF. (2022)s. Childcare in Humanitarian Crises: Programming models for acute onset emergencies.
- WHO.(2016).Astrategicframeworkforemergencypreparedness.Geneva.Licence:CCBY-NC-SA3.0IGO. Retrieved from: <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/254883/9789241511827-eng.pdf>
- WHO. (2016). Inspire: Seven strategies for ending violence against children. Geneva.



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN
📺 HairaarUlgerley